

**ЭМСЯ-ны харьяа
байгууллагуудын хэрэглэгчийн
сэтгэл ханамжийн судалгаа**

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Товчлол

Тайлбар

АӨСҮТ	-	Арьсны өвчин судлалын үндэсний төв
ГССҮТ	-	Гэмтэл, согог судлалын үндэсний төв
ГҮТ	-	Геронтологийн үндэсний төв
СЭМҮТ	-	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
УГТЭ	-	Улсын гуравдугаар төв эмнэлэг
УХТЭ	-	Улсын хоёрдугаар төв эмнэлэг
УНТЭ	-	Улсын нэгдүгээр төв эмнэлэг
ХӨСҮТ	-	Халдварт өвчин судлалын үндэсний төв
ХСҮТ	-	Хавдар судлалын үндэсний төв
ХТС	-	Хүүхдийн төв сувилал
ЭМБ	-	Эрүүл мэндийн байгууллага
ЭМСЯ	-	Эрүүл мэнд спортын яам
ЭХЭМҮТ	-	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв

ХЭ- хэвтэн эмчлүүлэгч

АҮ- амбулаторын үйлчлүүлэгч

АГУУЛГА

ХУРААНГУЙ

НЭГ. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ, СУДЛАГДСАН БАЙДАЛ

ХОЁР. СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ

ГУРАВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

БҮЛЭГ 1. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

БҮЛЭГ 2. БАЙГУУЛЛАГЫН СОЁЛ

- 2.1. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДАЛ
- 2.2. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛ
- 2.3. БАЙГУУЛЛАГЫН ДОТООД, ГАДААД ОРЧНЫ ТАВ ТУХ
- 2.4. БАЙГУУЛЛАГЫН СОЁЛЫН ТАЛААР ХЭРЭГЛЭГЧИД ЮУГ, ЯМАР БАЙХЫГ ХҮСЭВ

БҮЛЭГ 3. ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛ

- 3.1. ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙ
- 3.2. ЭМЧИЙН ХАРИЛЦАА, ЁС ЗҮЙ
- 3.3. СУВИЛАГЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТЭН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТНЫ ХАРИЛЦАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛ
- 3.4. ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛЫН ТАЛААР ХЭРЭГЛЭГЧИД ЮУГ, ЯМАР БАЙХЫГ ХҮСЭВ

БҮЛЭГ 4. ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

- 4.1. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДАЛ
- 4.2. ЭМНЭЛГИЙН ДЭМЖИХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДАЛ
- 4.3. ЭМНЭЛГИЙН ЭРҮҮЛ АХУЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ
- 4.4. ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААР ХЭРЭГЛЭГЧИД ЮУГ, ЯМАР БАЙХЫГ ХҮСЭВ

БҮЛЭГ 5. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 5.1. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ
- 5.2. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР ХЭРЭГЛЭГЧИД ЮУГ, ЯМАР БАЙХЫГ ХҮСЭВ

БҮЛЭГ 6. ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЭГШ БАЙДАЛ, АШИГ СОНИРХОЛ

- 6.1. ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЭГШ БАЙДАЛ
- 6.2. АШИГ СОНИРХОЛ
- 6.3. ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЭГШ БАЙДАЛ, АШИГ СОНИРХОЛЫН ТАЛААР ХЭРЭГЛЭГЧИД ЮУГ, ЯМАР БАЙХЫГ ХҮСЭВ
- 6.4. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР, ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГААС ХЭРЭГЛЭГЧИД, ЮУГ, ЯМАР БАЙХЫГ ХҮСЭВ

ДҮГНЭЛТ

ЗӨВЛӨМЖ

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ:

- ХҮСНЭГТ 1. СУДАЛГААНЫ ТҮҮВЭР
- ХҮСНЭГТ 2. ХЭРЭГЛЭГЧИЙН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ, ҮЙЛЧЛҮҮЛСЭН БАЙДАЛ
- ХҮСНЭГТ 3. БАЙГУУЛЛАГЫН СОЁЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН – БАЛЛ, ХУВИАР
- ХҮСНЭГТ 4. БАЙГУУЛЛАГЫН СОЁЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН (САЙН, ДУНД, МУУ) ҮНЭЛГЭЭ
- ХҮСНЭГТ 5. ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН
- ХҮСНЭГТ 6. ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ
- ХҮСНЭГТ 7. ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН
- ХҮСНЭГТ 8. ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ
- ХҮСНЭГТ 9. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН
- ХҮСНЭГТ 10. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ
- ХҮСНЭГТ 11. ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЭГШ БАЙДАЛ, АШИГ СОНИРХОЛ
- ХҮСНЭГТ 12. ХЭРЭГЛЭГЧДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ЕРӨНХИЙ ТҮВШИН

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- ЗУРАГ 1. НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН
- ЗУРАГ 2. НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ
- ЗУРАГ 3. ЛАВЛАГАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН
- ЗУРАГ 4. ЛАВЛАГАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ
- ЗУРАГ 5. УГТАХ, МЭНДЛЭХ, ХҮНДЛЭХ, ҮЙЛЧЛЭХ СОЁЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН
- ЗУРАГ 6. УГТАХ, МЭНДЛЭХ, ХҮНДЛЭХ, ҮЙЛЧЛЭХ СОЁЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ
- ЗУРАГ 7. БҮРТГЭХ, ЛАВЛАГАА МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН
- ЗУРАГ 8. БҮРТГЭХ, ЛАВЛАГАА МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ
- ЗУРАГ 9. АЖИЛТНЫ ХУВЦАСЛАЛТЫН СОЁЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН
- ЗУРАГ 10. АЖИЛТНЫ ХУВЦАСЛАЛТЫН СОЁЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ
- ЗУРАГ 11. БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ОРЧНЫ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН
- ЗУРАГ 12. БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ОРЧНЫ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ
- ЗУРАГ 13. БАЙГУУЛЛАГЫН ҮЗЛЭГ, ОНОШИЛГООНЫ ӨРӨӨНИЙ ХАЯГЖИЛТЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН
- ЗУРАГ 14. БАЙГУУЛЛАГЫН ҮЗЛЭГ, ОНОШИЛГООНЫ ӨРӨӨНИЙ ХАЯГЖИЛТЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ
- ЗУРАГ 15. БАЙГУУЛЛАГЫН ГАДААД ОРЧНЫ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН
- ЗУРАГ 16. БАЙГУУЛЛАГЫН ГАДААД ОРЧНЫ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ
- ЗУРАГ 17. БАЙГУУЛЛАГЫН МАШИНЫ ЗОГСООЛЫН ХҮРТЭЭМЖИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН
- ЗУРАГ 18. БАЙГУУЛЛАГЫН МАШИНЫ ЗОГСООЛЫН ХҮРТЭЭМЖИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ
- ЗУРАГ 19. БАЙГУУЛЛАГЫН СОЁЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН
- ЗУРАГ 20. ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН
- ЗУРАГ 21. ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ
- ЗУРАГ 22. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН НУУЦ ХАДГАЛАЛТЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН
- ЗУРАГ 23. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН НУУЦ ХАДГАЛАЛТЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ
- ЗУРАГ 24. ЭМЧИЙН ХАРИЛЦАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН
- ЗУРАГ 25. ЭМЧИЙН ХАРИЛЦАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ
- ЗУРАГ 26. ЭМЧИЙН СОНСОХ, ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ УР ЧАДВАРЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН
- ЗУРАГ 27. ЭМЧИЙН СОНСОХ, ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ УР ЧАДВАРЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ
- ЗУРАГ 28. СУВИЛАГЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ХАРИЛЦАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН
- ЗУРАГ 29. СУВИЛАГЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ХАРИЛЦАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛЫН

СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ

- ЗУРАГ 30. СУВИЛАГЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ СОНСОХ, ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ УР
ЧАДВАРЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН
- ЗУРАГ 31. СУВИЛАГЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ СОНСОХ, ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ УР
ЧАДВАРЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ
- ЗУРАГ 32. АСАРГАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТНЫ ХАРИЛЦАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛЫН
СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН
- ЗУРАГ 33. АСАРГАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТНЫ ХАРИЛЦАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛЫН
СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ
- ЗУРАГ 34. ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТЭН, АЖИЛТНЫ ЁС ЗҮЙ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛЫН
СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН
- ЗУРАГ 35. ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ АЖЛЫН ХАРИУЦЛАГА, ШУУРХАЙ БАЙДЛЫН
СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН
- ЗУРАГ 36. ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ АЖЛЫН ХАРИУЦЛАГА, ШУУРХАЙ БАЙДЛЫН
СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ
- ЗУРАГ 37. ОНОШИЛГООНЫ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН
- ЗУРАГ 38. ОНОШИЛГООНЫ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ
- ЗУРАГ 39. ЭМЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН
- ЗУРАГ 40. ЭМЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ
- ЗУРАГ 41. СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН
- ЗУРАГ 42. СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ
- ЗУРАГ 43. ЭМ ОЛГОХ, ТҮГЭЭХ, ТАРИА ХИЙХ ҮЙЛДЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН
- ЗУРАГ 44. ЭМ ОЛГОХ, ТҮГЭЭХ, ТАРИА ХИЙХ ҮЙЛДЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ
- ЗУРАГ 45. БАРИЛГА БАЙГУУЛАМЖЫН ЭРҮҮЛ АХУЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН
- ЗУРАГ 46. БАРИЛГА БАЙГУУЛАМЖЫН ЭРҮҮЛ АХУЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ
- ЗУРАГ 47. ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН
- ЗУРАГ 48. ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ
- ЗУРАГ 49. АСАРГААТАЙ, ХҮНД ӨВЧТЭЙ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН АЮУЛГҮЙ
БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН
- ЗУРАГ 50. АСАРГААТАЙ, ХҮНД ӨВЧТЭЙ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН АЮУЛГҮЙ
БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ
- ЗУРАГ 51. ЭМНЭЛГИЙН ХАЛААЛТЫН СИСТЕМ, УСАН ХАНГАМЖИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ
СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН
- ЗУРАГ 52. ЭМНЭЛГИЙН ХАЛААЛТЫН СИСТЕМ, УСАН ХАНГАМЖИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ
СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ
- ЗУРАГ 53. ЭМНЭЛГИЙН ХООЛНЫ АМТ ЧАНАРЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН
- ЗУРАГ 54. ЭМНЭЛГИЙН ХООЛНЫ АМТ ЧАНАРЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ
- ЗУРАГ 55. ЭМЧИЛГЭЭ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН
СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН
- ЗУРАГ 56. ЭМЧИЛГЭЭ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН
СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ
- ЗУРАГ 57. ЭМНЭЛГИЙН ЭРҮҮЛ АХУЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН
- ЗУРАГ 58. ЭМНЭЛГИЙН ЭРҮҮЛ АХУЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ
- ЗУРАГ 59. ЭМНЭЛГИЙН УГААЛГА, ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН
- ЗУРАГ 60. ЭМНЭЛГИЙН УГААЛГА, ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ
- ЗУРАГ 61. ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН
ТҮВШИН
- ЗУРАГ 62. КАБИНЕТ, ТАСАГ НЭГЖИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН
ТҮВШИН
- ЗУРАГ 63. КАБИНЕТ, ТАСАГ НЭГЖИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН
ҮНЭЛГЭЭ
- ЗУРАГ 64. УДИРДЛАГААС ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАН, САНАЛЫГ СОНСДОГ БАЙДЛЫН
СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН
- ЗУРАГ 65. УДИРДЛАГААС ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАН, САНАЛЫГ СОНСДОГ БАЙДЛЫН

ЭМСЯ-НЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ

- ЗУРАГ 66. ИРГЭДИЙН САНАЛ, ХҮСЭЛТИЙГ ШИЙДВЭРЛЭН ЭРГЭН МЭДЭЭЛДЭГ БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН
- ЗУРАГ 67. ИРГЭДИЙН САНАЛ, ХҮСЭЛТИЙГ ШИЙДВЭРЛЭН ЭРГЭН МЭДЭЭЛДЭГ БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ
- ЗУРАГ 68. ЭРҮҮЛ МЭНДИЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН
- ЗУРАГ 69. ЭРҮҮЛ МЭНДИЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ
- ЗУРАГ 70. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТАД СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН
- ЗУРАГ 71. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛГҮЙГЭЭР ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ БОЛОМЖ
- ЗУРАГ 72. ЭМЧЭЭ СОНГОН ҮЗҮҮЛЭХ БОЛОМЖ
- ЗУРАГ 73. ЭМНЭЛЭГТ ТАНИХ ХҮНГҮЙ БОЛ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ АВАХАД ХҮНДРЭЛТЭЙ
- ЗУРАГ 74. ЭМНЭЛЭГТ ХЭВТЭХЭД ГАДНААС ЭМ ТАРИА АВХУУЛДАГ
- ЗУРАГ 75. ШАН ХАРАМЖ, АЛБАН БУС ТӨЛБӨР
- ЗУРАГ 76. ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ХУВИЙН АШИГ СОНИРХОЛ
- ЗУРАГ 77. ХЭРЭГЛЭГЧДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ЕРӨНХИЙ ТҮВШИН

ХУРААНГУЙ

Энэхүү судалгаа нь 6 бүлэг, 20 дэд бүлэг бүхий үр дүнгийн тайлан, дүгнэлт, зөвлөмж болон 12 хүснэгт, 77 дүрслэлээс бүрдэж байна.

Судалгаанд тоон судалгааны аргыг ашиглан, 35-39 хувьсах хэмжигдэхүүн бүхий хаалттай асуулт, **“ТА БИДНЭЭС ЮУГ, ЯМАР БАЙХЫГ ХҮСЧ БАЙНА ВЭ”** гэсэн 1 нээлттэй асуултаар хэрэглэгчдийн сэтгэл ханамж, санал, хүсэлтийг тодорхойлохыг хичээлээ.

Эрүүл мэндийн байгууллага, эмч, эмнэлгийн мэргэжилтэн маш их ачаалалтай ажиллаж, эрүүл мэндийн салбар, эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээ, үйл ажиллагаа сайжирч байгаад олон үйлчлүүлэгчид талархал илэрхийлэн, ажилд нь амжилт хүсэн, улам сайн ажиллаарай гэснийг эхлэн онцолж байна.

Судалгаанд ЭМСЯ-ны харьяа 10 эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлсэн 1596 хэвтэн эмчлүүлэгч, 1490 амбулаторын үйлчлүүлэгч, нийт 3087 хэрэглэгч хамрагдлаа. Түүвэр нь 95.4%-ийн үнэн магадлалыг хангаж байна. Судалгаанд хамрагдсан 3087 хэрэглэгчийн 38.4% эрэгтэйчүүд, 61.6 хувь нь эмэгтэйчүүд дийлэнх нь 20-49 насныхан буюу 62.3% байна. Нийт оролцогчдын 55.2 хувь нь тухайн эмнэлгээр анх удаа үйлчлүүлсэн, 44.8% нь 2 ба түүнээс дээш удаа үйлчлүүлсэн хүмүүс байна.

Судалгаанд хамрагдсан 1596 хэвтэн эмчлүүлэгчийн сэтгэл ханамжийн ерөнхий дундаж түвшин 87.6%, 1.25 баллтай, 1490 амбулаторын үйлчлүүлэгчдийнх 80.9%, 1.36 баллтай, сэтгэл ханамжийн түвшин “сайн” үнэлгээтэй байна.

Сэтгэл ханамжийн ерөнхий түвшинг бүлгээр, амбулатор:стационараар харьцуулан авч үзвэл, байгууллагын соёлд 79.5:85.5%, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёлд 84.6:91.4%, тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдалд 81.4:88.4%, удирдлага зохион байгуулалтад 76.8:83.8%-ийн сэтгэл ханамжтай байна.

Сэтгэл ханамжгүй байдлын ерөнхий түвшинг амбулатор:стационараар харьцуулан авч үзвэл, байгууллагын соёлд $17.5 \pm 3\%$, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёлд $12.0 \pm 3.4\%$, тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдалд $15.1 \pm 3.5\%$, удирдлага зохион байгуулалтад $19.7 \pm 3.5\%$ -ийн сэтгэл ханамжгүй байдал харагдаж байна. Байгууллагаар авч үзвэл хэвтэн эмчлүүлэгчдийн үнэлгээ амбулаторын үйлчлүүлэгчдээс тогтмол өндөр байна.

Хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн ерөнхий түвшин өндөр (90.0-ээс дээш хувьтай) байгууллагад ХСҮТ, УИТЭ, УИТЭ, СЭМҮТ, ХТС, амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин өндөр байгууллагад СЭМҮТ, ХТС, ГҮТ орж байна. Хамгийн бага нь ГССҮТ нь 69.7%-тай, 1.61 баллтай байна.

Байгууллагын соёлд хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 85.3%, амбулаторын үйлчлүүлэгчдийнх 79.5%-тай, баллаар авч үзвэл 1.29-1.41 буюу сэтгэл ханамж “сайн” байна. Байгууллагаар авч үзвэл ХСҮТ, СЭМҮТ, УИТЭ, ХТС-ийн хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин өндөр байгаа бол ГССҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 65.0%тай, “дунд” үнэлгээтэй байна.

Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ёс зүй, харилцаа, үйлчилгээний соёлд УИТЭ, УИТЭ, ЭХЭМҮТ, СЭМҮТ, ХСҮТ, АӨСҮТ, ХТС-ийн хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин өндөр, ГССҮТ нь амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 70.8%тай байгаа нь хамгийн бага үзүүлэлт болж байна.

Удирдлага зохион байгуулалтад УИТЭ, СЭМҮТ, ХСҮТ-ийн хэвтэн эмчлүүлэгчид, ГҮТ-ийн үйлчлүүлэгчид өндөр үнэлгээ өгсөн бол ГССҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 58.0%тай байгаа нь дунд үнэлгээ юм.

Тусламж, үйлчилгээний тэгш байдал, ашиг сонирхол: Тусламж, үйлчилгээний хүлээгдэл, шуурхай үйлчилгээтэй холбоотойгоор тэгш байдал алдагдах, ашиг сонирхолын зөрчил үүсдэг гэж оролцогчдын 11.4-38.8% нь зөвшөөрсөн байна. Эмнэлэгт таних хүнгүй бол тусламж, үйлчилгээ авахад хүндрэлтэй, гаднаас эм тариа авчруулж байгаа нь хамгийн их бухимдал үүсгэж байна. Энэ нь нээлттэй асуулгаар судлагдсан тусламж, үйлчилгээ хүлээгдэл ихтэй, цахим бүртгэлийн зохион байгуулалт, үйлчилгээний соёл хангалтгүй, эмч, эмнэлгийн мэргэжилтний чин сэтгэлийн харилцаа, ёс зүй, инээмсэглэн угтаж, мэндчлэх болон зөвлөгөө өгөх үйлчилгээ дутагдалтай, үйлчлүүлэгчиддээ ялгавартай ханддаг, гаднаас эм тариа авчруулдаг, зарим тохиолдолд албан бус төлбөр өгөх шаардлага гардаг зэрэгтэй шууд хамааралтай байна.

НЭГ. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ, СУДЛАГДСАН БАЙДАЛ

Монгол улсад хэрэглэгч төвтэй, тэдний хэрэгцээнд нийцсэн чанартай, аюулгүй, ёс зүйтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чухалчилж байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаарх хэрэглэгчийн сэтгэл ханамж нь тухайн байгууллагын үйлчилгээнээс гадна өвчний эдгэрэл болон үйлчлүүлэгчийн тухайн үеийн сэтгэл зүй, хандлагатай уялдсан хийсвэр хүчин зүйлсийн нөлөө ихтэй байдгаараа бусад салбараас онцлог байдаг.

Эрүүл мэндийн хөгжлийн төв нь “Эрүүл мэндийн байгууллагын жилийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлэх” ажлын нэг үзүүлэлт болгон Эрүүл мэнд, спортын яамны (ЭМСЯ)-ны харьяа эрүүл мэндийн байгууллагуудад жилд нэг удаа, нэгдсэн зохион байгуулалттайгаар сэтгэл ханамжийн судалгаа хийдэг.

Эрүүл мэндийн сайдын 2014 оны “Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны аргачлал батлах тухай” 13 дугаар тушаал гарч, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг нийслэлд, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн хөгжлийн төв, аймагт аймгийн Эрүүл мэндийн газар тус тус зохион байгуулахаар даалгасан.

Энэ дагуу 2015 онд ЭМХТ нь энэхүү аргачлалын дагуу тухайн жилийн онцлогтой уялдуулан зарим нэг нэмэлт хэмжигдэхүүнийг оруулан, судалгаа хийж, үр дүнгийн тайланг ЭМСЯ-ны ХШҮДАГ-т хүргүүлсэн.

2015 онд тус газраас энэхүү судалгааг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх шийдвэр гаргаж, Эрүүл мэнд спортын сайдын 2015 оны 10 сарын 19-ний өдөр баталсан удирдамжаар хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг “Монголын хөгжлийн тулах цэг” төрийн бус байгууллага гүйцэтгэсэн байна.

Мөн 2016 оны 03 дугаар сарын 01-ны өдөр хуралдсан ЭМСЯ-ны удирдлагын зөвлөлийн хурлаар энэхүү судалгааг ЭМХТ-өөр 2016.03.09-03.18-ны дотор хийлгэхээр шийдвэрлэсэн.

Судалгааг шахуу цаг хугацаанд, 13 өдөрт багтаан хийх шаардлагатай тул энэ удаа үйлчилгээ үзүүлэгч буюу эмч, эмнэлгийн мэргэжилтний сэтгэл ханамжийг тусгайлан судлаагүй болно.

Зорилго: Эрүүл мэнд, спортын яамны харьяа байгууллагуудын хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг судлан, шийдвэр гаргагчдыг нотолгоонд суурилсан мэдээллээр хангах.

Зорилт:

- Амбулаторын үйлчлүүлэгчид, хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг судлах
- Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх түвшинд нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргахад мэдээллээр хангах

Үр дүн:

- Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг тодорхойлсон судалгааны үр дүнгийн тайлан бичигдэнэ.
- Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх түвшинд нотолгоогоор хангагдана.

ХОЁР. СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ

Судалгааны аргачлал: Тоон судалгааны аргаар тусгайлан боловсруулсан 35-39 хувьсах ба үл хувьсах хэмжигдэхүүн бүхий асуумжаар, өөрсдөөр нь бөглүүлэх аргаар явуулав. Судалгааны асуулгад 1 асуудлыг нээлттэй бөглөхөөр оруулсан болно.

Судалгааны хамрах хүрээ: ЭМСЯ-ны харьяа төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдээс амбулаторын болон хэвтэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээ үзүүлдэг 10 байгууллагыг зориудаар сонгов.

Судалгааны нэгж, түүвэрлэлтийн тоо: Судалгааны нэгж нь ЭМСЯ-ны харьяа эрүүл мэндийн байгууллагуудын амбулатор болон стационариар тухайн агшинд үйлчлүүлж байсан үйлчлүүлэгчид, хэвтэн эмчлүүлэгчид байв.

Амбулаторын сэтгэл ханамжийн судалгааны түүвэрлэлтийн тоог тогтоохдоо тухайн эмнэлгийн амбулаториор 1 жилд үйлчлүүлсэн хүний тооноос 1 өдөрт үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдийн тоог тооцоолон эх олонлогоор авлаа. Хэвтэн эмчлүүлэгчдийг түүврийн тоог тогтоохдоо тухайн эмнэлгийн орны тоог эх олонлогоор авлаа.

Түүврийн тоог дараах томъёогоор байгууллага бүрээр тооцоолон тогтоосон бөгөөд энэхүү түүвэрлэлт нь 95.4%-ийн үнэн магадлалыг хангана.

$$n = \frac{t^2 \cdot w(1-w) \cdot N}{N \cdot \Delta_p^2 + t^2 \cdot w(1-w)}$$

- ❖ *t-баталгааны коэффициентийг 95.4 хувийн үнэн магадлалтай байхаар t= 2 авлаа.*
- ❖ *w(1-w)- дунджаас хазайх хазайлтын квадрат буюу дисперсийг 0.25-аар тооцоолов.*
- ❖ *N- эх олонлогийн хэмжээ*
- ❖ *Дельта- Алдааны хязгаар ба 0.05 аар авлаа.*
- ❖ *n- түүврийн хэмжээ болно.*

ХҮСНЭГТ 1. СУДАЛГААНЫ ТҮҮВЭР

№	Эмнэлгийн нэр	Хэвтэн эмчлүүлэгч		Амбулаторын үйлчлүүлэгч			Нийт Түүвэр
		Орны тоо	Түүврийн тоо	Жилд үйлчлүүлсэн хүний тоо	1 өдөрт үйлчлүүлсэн хүний тоо	Түүврийн тоо	
1	УИТЭ	500	222	304758	1154	297	519
2	УИТЭ	195	131	91906	348	186	317
3	УИИТЭ	430	207	161810	613	242	449
4	ЭХЭМҮТ	665	250	145153	550	232	481
5	ХӨСҮТ	530	228	72513	275	163	391
6	СЭМҮТ*	60	52	5047	19	18	70
7	ГССҮТ	412	203	32000	121	93	296
8	ХСҮТ	215	140	55343	210	138	277
9	АӨСҮТ	170	119	72966	276	163	283
10	ХТС	50	44	-	-	-	44
11	ГҮТ	-	-	16443	62	54	54
		3227	1596	957939	3629	1586	3182

Судалгааны мэдээлэл цуглуулах хэрэгсэл (асуумж карт):

- Амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн асуумж-5 бүлэг 35 хувьсах хэмжигдэхүүн, 1 нээлттэй асуумж, 3 үл хувьсах хэмжигдэхүүн бүхий асуулга
- Хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн асуумж-5 бүлэг 39 хувьсах хэмжигдэхүүн, 1 нээлттэй асуумж, 3 үл хувьсах хэмжигдэхүүн бүхий асуулга

Мэдээ, мэдээллийг боловсруулах: Мэдээллийг SPSS-20.0 болон Excel програмуудыг ашиглан статистикийн энгийн шинжилгээний аргыг ашиглан, үр дүнгийн шинжилгээ хийсэн.

ЭМСЯ-НЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

Сэтгэл ханамжийн байдлыг илэрхийлэх 2 үзүүлэлтийг тооцон гаргасан. Үүнд:

1. Сэтгэл ханамжийн түвшин (балл болон хувиар)
 - Эрүүл мэндийн байгууллага бүрээр
 - Үзүүлэлт бүрээр
2. Сэтгэл ханамжийн үнэлгээ (“сайн”, “дунд”, “муу”) эзлэх хувь
 - Эрүүл мэндийн байгууллага бүрээр
 - Үзүүлэлт бүрээр

Сэтгэл ханамжийн түвшинг балл болон хувиар илэрхийлэхдээ Эрүүл мэндийн сайдын 2014 оны 6/182 тушаалд заасны дагуу “сайн”, “дунд”, “муу” гэсэн хариултуудад хүснэгтэд заасан харгалзах оноо/балл өгөн дундаж баллыг олж, тухайн дундаж баллыг хувьд шилжүүлэн тооцсон.

Дундаж баллыг хувьд шилжүүлэхдээ: Тухайн үзүүлэлтийн сэтгэл ханамжийн хувь = 0% + (3-Тухайн үзүүлэлтийн дундаж оноо)*50% томъёогоор шилжүүлэн бодсон болно. Үүнд:

0% – Сэтгэл ханамж муу буюу 3 гэсэн оноонд харгалзах хувь

3 – Сэтгэл ханамж муу гэсэн хариултад харгалзах оноо

50% нь 1-3 гэсэн онооны 1 бүхэл интервалд ногдох хувь (тогтмол тоо)

Үзүүлэлт	Сайн	Дунд	Муу
Сэтгэл ханамжийн оноо/балл	1	2	3
Сэтгэл ханамжийн түвшин (хувиар)	66.8-100	33.4-66.7	0-33.3

Харин тухайн хариултын (“сайн”, “дунд”, “муу”) эзлэх хувийг тооцохдоо тухайн эрүүл мэндийн байгууллагаар болон үзүүлэлтийн нийт хариултад тухайн хариултын эзлэх хувиар тооцсон болно.

Судалгааны ажлын хүн хүчин: Судалгааны мэдээлэл цуглуулах багт Эрүүл мэндийн хөгжлийн төвийн мэргэжилтэн Б.Доржмягмар, С.Түмэнбаяр, Д.Ариунаа, Н.Нарангэрэл, Ц.Одончимэг, Д.Одбаяр, Л.Бор, Э.Ундармаа, Я.Бадамсүрэн, Б.Дарьбум, Э.Батжаргал, Б.Батцоож, Д.Банзрагч, Д.Баярхүү, С.Баясгалан нар ажиллан, мэдээллийг Т.Өнөрцэцэг боловсруулан, үр дүнгийн тайланг Л.Ширнэн бичлээ.

Судалгааны бэрхшээл: ЭМСЯ-ны 2016 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн удирдлагын зөвлөлийн хурлаар хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг хийж, 3 дугаар сарын 18-ны дотор тайланг ирүүлэхийг даалгасан. Тус шийдвэр нь 03 дугаар сарын 07-ны өдөр ЭМХТ-д ирсэнээр, 03.09-ны өдрөөс эхлэн гүйцэтгэж, 3087 хүнээс мэдээлэл цуглуулан, мэдээллийг шивэн боловсруулалт хийж, үр дүнгийн тайланг 15-ны өдрөөс эхлэн 5 хоногт бичсэн бөгөөд судалгааны хугацаа маш давчуу, тайланг олон дахин нягтлан унших, найруулах боломж бага байлаа. Мөн ХӨСҮТ-ийн амбулаториор тухайн агшинд үйлчлүүлсэн хүний тоо түүвэрт хүрээгүй боловч, дахин очих хугацаа бага байв.

Мэдээллийг түгээх: Сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгийн тайланг ЭМСЯ-ны ХҮШДАГ-т хүргүүлэв. Судалгааны үр дүнг шийдвэр гаргагч, хэрэглэгчдэд нээлттэй мэдээлнэ.

ГУРАВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Үр дүнгийн тайланг бичихдээ бүлэг бүрт аргачлалын дагуу сэтгэл ханамжийг байгууллага бүрээр харьцуулан, сайн, дунд, муу гэж үнэлсэн хувийг “сэтгэл ханамжийн үнэлгээ”, сэтгэл ханамжийн үнэлгээний дундаж үзүүлэлтийг балл руу шилжүүлэн, хувиар тооцсоныг “сэтгэл ханамжийн түвшин” гэж авч үзэн, тайлбар дүгнэлт хийлээ.

Амбулаторын 35 хэмжигдэхүүн, хэвтэн эмчлүүлэгчдийн 39 хэмжигдэхүүний 4 хэмжигдэхүүнээс бусад нь ижил учраас агуулгаар болон байгууллага бүрээр сэтгэл ханамжийн түвшин, үнэлгээг харьцуулан дүн шинжилгээ хийлээ.

Судалгаанд “**ТА БИДНЭЭС ЮУГ, ЯМАР БАЙХЫГ ХҮСЧ БАЙНА ВЭ**” гэсэн нээлттэй асуултаар хэрэглэгчдийн санал, хүсэлт, тулгамдсан асуудал, бэрхшээл хүндрэл, эрүүл мэндийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлохыг хичээлээ.

Эрүүл мэндийн байгууллага, эмч, эмнэлгийн мэргэжилтэн маш их ачаалалтай ажиллаж, эрүүл мэндийн салбар, эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээ, үйл ажиллагаа сайжирч байгаад олон хэрэглэгч талархал илэрхийлэн, ажилд нь амжилт хүссэн, улам сайн ажиллаарай гэснийг онцлон

ЭМСЯ-НЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

тэмдэглэж байна. Ялангуяа хэвтэн эмчлүүлэгчид эмч сувилагч, тасаг нэгжийн нэрийг дурдан баярласнаа илэрхийлэн, амжилт хүссэн байна.

“Та биднээс юуг, ямар байхыг хүсч байна вэ” гэсэн нээлттэй асуултад иргэдийн дийлэнх нь зөвлөгөө, хүсэлт байдлаар бодол санаагаа илэрхийлсэн бол зарим нэг нь нилээдгүй бухимдсан, жишээ баримт дурдсанг судалгааны ёс зүйг баримтлан нэр дурдалгүй тайланд нээлттэй оруулсан болно.

Нээлттэй асуулгад дүн шинжилгээ хийхдээ сэтгэл ханамжийн судалгааны үндсэн агуулгын дагуу бүлэглэн, олонхийн санал, үзэл бодолд тулгуурлан дүн шинжилгээ хийж, зарим нэг санал бодлыг нотолгоо болгон, асуудал дэвшүүлэн, бодлого, шийдвэр гаргагчдын түвшинд анхаарал хандуулахыг хүсэн, хэрэглэгчийн хэлсэнээр буулгав.

Үр дүнгийн тайлан бичих дизайныг гаргахдаа бүлгийн эхэнд тоон судалгааны үр дүнг дээр хэлсэн 2 үзүүлэлт буюу сэтгэл ханамжийн түвшин, сэтгэл ханамжийн үнэлгээ бүрээр зургаар харуулан, амбулаторын үйлчлүүлэгчид, хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг ерөнхий дүнгээр харьцуулав.

Байгууллагаар авч үзэхдээ сэтгэл ханамжийн түвшин болон үнэлгээ 90.0-ээс дээш хувьтай байвал сэтгэл ханамж өндөр гэж үзэн, сэтгэл ханамжгүй байдлыг тухайн үзүүлэлтээр хамгийн бага хувьтай байгууллагыг онцлон тайлбар хийв.

Бүлэг бүрийн тоон үзүүлэлтийн дараа, сэтгэл ханамжгүй байдал нь энэхүү шалтгаантай холбоотой байж болно гэсэн таамаглал дэвшүүлэн, нээлттэй асуулгад дүн шинжилгээ хийсэн хэсгээ бүлэглэн оруулсан болно.

Энэ нь эмнэлгийн удирдлагууд өөрсдийн хэрэглэгчдийн санал, хүсэлт, басхүү бухимдал, бэрхшээлийг мэдрэх, нотолгоонд тулгуурлан асуудлыг шийдвэрлэхэд чухлыг харгалзан, хэрэглэгчдийн санал, хүсэлтийг байгууллага бүрээр, давхардсан санааг нэгтгэн хүргэв.

БҮЛЭГ 1. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

Судалгаанд батлагдсан аргачлал, түүврийн дагуу, ЭМСЯ-ны харьяа амбулаторын болон хэвтэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээ үзүүлдэг 3 төв эмнэлэг, 7 тусгай мэргэжлийн төв, нийт 10 байгууллага хамрагдлаа.

Түүврийн дагуу 1596 хэвтэн эмчлүүлэгч, 1586 амбулаторын үйлчлүүлэгч хамрагдах шаардлагатай байснаас, хэвтэн эмчлүүлэгчийн түүврийн тоо 100.0% хангагдаж, амбулаторын үйлчлүүлэгчийн тоо 93.9% (1490) хангагдаж, нийт 3087 хүн судалгаанд оролцов.

Хэрэглэгчийн судалгааг 95.4%-ийн үнэн магадтай байдлыг ханган, тухайн агшинд үйлчлүүлж байгаа иргэдээс санамсаргүй энгийн аргаар, тасаг, нэгж бүрийг жигд хамруулан авлаа.

СЭМҮТ-ийн тусламж, үйлчилгээний онцлогоос хамааран, эх олонлогоор дондолт, мэдрэлийн тасгийн орны тооноос болон, амбулаторын үзлэгээс түүврийн тоог тогтоосон. ГҮТ-ийн хувьд амбулаторын үйлчилгээ үзүүлсэн тооноос түүврийн тоог тогтоосон.

ХҮСНЭГТ 2. ХЭРЭГЛЭГЧИЙН НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ, ҮЙЛЧЛҮҮЛСЭН БАЙДАЛ

Эмнэлгийн нэр	Хүйс		Нас							Үйлчлүүлсэн тоо	
	Эр	Эм	-15	15-19	20-29	30-39	40-49	50-59	60+	Анх удаа	2 ба түүнээс дээш
УИТЭ	45.3	54.7	0.0	1.2	15.6	22.0	24.5	22.5	14.3	59.0	41.0
УИИТЭ	29.3	70.7	0.9	0.6	3.2	11.0	11.0	21.1	52.1	23.7	76.3
УИИТЭ	42.8	57.2	0.2	0.9	17.8	19.8	22.9	19.2	19.2	50.8	49.2
ЭХЭМҮТ	23.1	76.9	10.3	7.2	31.8	31.2	14.8	3.8	0.9	53.7	46.3
ХӨСҮТ	44.6	55.4	4.9	7.7	42.2	21.6	12.5	7.7	3.5	76.0	24.0
СЭМҮТ	48.6	51.4	0.0	0.0	10.0	18.6	38.6	18.6	14.3	61.4	38.6
ГССҮТ	48.4	51.6	6.2	2.2	20.4	24.5	23.4	15.7	7.7	78.5	21.5
ХСҮТ	37.9	62.1	0.0	1.5	6.1	14.1	31.6	23.6	23.2	52.1	47.9
АӨСҮТ	38.7	61.3	0.4	4.3	31.6	27.0	19.1	10.6	7.1	58.2	41.8
ГҮТ	26.9	73.1	8.4	0.0	13.7	15.8	4.2	7.4	50.5	46.5	53.5
Дундаж	38.4	61.6	3.0	2.9	20.5	21.6	20.0	15.5	16.6	55.2	44.8

ЭМСЯ-НЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

Судалгаанд оролцогчдын 38.4% эрэгтэйчүүд, 61.6 хувь нь эмэгтэйчүүд байна. Насны бүлгээр авч үзвэл 15-19 насныхан 2.9%, 20-29 насныхан 20.5%, 30-39 насныхан 21.6%, 40-49 насныхан 20.0%, 50-59 насныхан 15.5%, 60 ба дээш насныхан 16.6%, 15-аас доош насныхан 3.0 байна. Тэдний 55.2 хувь нь тухайн эмнэлгээр анх удаа үйлчлүүлж байгаа 44.8% нь 2 ба түүнээс дээш удаа үйлчлүүлсэн хүмүүс байна. Байгууллагаар авч үзвэл ХӨСҮТ, СЭМҮТ, ГССҮТ-ийн үйлчлүүлэгчдийн дийлэнх нь анх удаа УИТЭ, ГҮТ-ийн үйлчлүүлэгчдийн дийлэнх давтан үйлчлүүлэгчид байна.


БҮЛЭГ 2. БАЙГУУЛЛАГЫН СОЁЛ

Судалгаанд эрүүл мэндийн байгууллагын соёлыг гадаад дотоод орчны тав тухтай байдал, үйлчилгээний соёл, лавлагаа мэдээлэл, эмч, эмнэлгийн мэргэжилтний хувцаслалт зэргийг хамааруулсан 9 хэмжигдэхүүнээр тодорхойлсон.

2.1. Байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдал


Байгууллагын үйл ажиллагааг видео танилцуулга болон бусад хэлбэрээр нээлттэй, ил тод мэдээлэх талаар судалгаанд хамрагдсан 1596 хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 86.5%-тай, 1490 амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 83.6%-тай, баллаар авч үзвэл 1.27-1.33 буюу “сайн” үнэлгээтэй байна.

ЗУРАГ 1. НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН




Сэтгэл ханамжийн түвшинг байгууллагаар авч үзвэл СЭМҮТ, ХСҮТ, ГҮТ хамгийн өндөр хувьтай байгаа бол ГССҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 59.7%-тай, “дунд” үнэлгээтэй байна.

ЗУРАГ 2. НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ




Байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хэвтэн эмчлүүлэгчдийн 75.1% нь, амбулаторын үйлчлүүлэгчдийн 69.8% нь сайн гэж үнэлсэн ба 27.5± 2.67 % нь сэтгэл ханамжгүй дунд, муу гэж үнэлжээ. Хэвтэн эмчлүүлэгч, амбулаторын сэтгэл ханамжийн үнэлгээ байгууллага бүрээр харилцан адилгүй боловч ХСҮТ, ГҮТ, СЭМҮТ-ийн сэтгэл ханамжын үнэлгээ өндөр хувьтай, ГССҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн үнэлгээ хамгийн бага (33.3%) хувьтай байна. Мөн ХӨСҮТ-ийн хэвтэн эмчлүүлэгч, ЭХЭМҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгч 40.0 орчим хувь нь сэтгэл ханамжгүй байна.

ЗУРАГ 3. ЛАВЛАГАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН



Лавлагаа үйлчилгээний талаар шаардлагатай мэдээллийг иргэд, үйлчлүүлэгчдэд ил тод, нээлттэй, харагдахуйц хэмжээнд байрлуулсан талаар хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн (87.8%) түвшин амбулаторын (82.4%) үйлчлүүлэгчдээс 5.4%-иар өндөр байна.

ЗУРАГ 4. ЛАВЛАГАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ




Харин сэтгэл ханамжийн үнэлгээг байгууллага тус бүрээр авч үзвэл ХСҮТ, УИИТЭ-ийн хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамж өндөр байгаа бол УИТЭ, УИИТЭ, ЭХЭМҮТ, ХӨСҮТ, ГССҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин “дунд” байна.

2.2. Үйлчилгээний соёл

Байгууллагын *угтаж, мэндлэх, хүндлэх, үйлчлэх* соёлд хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 87.9%-тай, амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 79.9%-тай, 8.0%-ийн зөрүүтэй, баллаар авч үзвэл 1.24-1.40 буюу “сайн” үнэлгээтэй байна.


ЗУРАГ 5. УГТАХ, МЭНДЛЭХ, ХҮНДЛЭХ, ҮЙЛЧЛЭХ СОЁЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН



ЭМСЯ-НЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

Үйлчилгээний соёлын сэтгэл ханамжийн түвшинг байгууллагаар авч үзвэл УИТЭ, УИИТЭ, ХТС, ХСҮТ, АӨСҮТ-ийн хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 90.0-ээс дээш хувьтай байгаа бол 80.0-аас доош хувьтай байгууллага байхгүй байна. Харин амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшингээр ГҮТ нь хамгийн өндөр хувьтай байгаа бол ЭХЭМҮТ нь 65.3%-тай, 1.69 баллтай, сэтгэл ханамжийн түвшин дунд үнэлгээтэй байна.

ЗУРАГ 6. УГТАХ, МЭНДЛЭХ, ХҮНДЛЭХ, ҮЙЛЧЛЭХ СОЁЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ




Үйлчилгээний соёлын сэтгэл ханамжийн үнэлгээгээр хэвтэн эмчлүүлэгчдийн 78.2% нь, амбулаторын үйлчлүүлэгчдийн 67.1% нь сайн гэж үнэлсэн бол $27.3 \pm 5.57\%$ нь сэтгэл ханамжгүй байна.

Байгууллагаар авч үзвэл УИТЭ, УИИТЭ, ХТС, ХСҮТ-ийн хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамж 90.0-ээс дээш хувьтай байна. Харин амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж төдийлөн өндөр биш, ялангуяа ЭХЭМҮТ, ХӨСҮТ, ГССҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж хангалтгүй байна.

Бүртгэх, лавлагаа мэдээлэл өгөх үйлчилгээний соёлд хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 88.9%, амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 82.6%-тай, хэвтэн эмчлүүлэгчид 6.3%-иар сэтгэл ханамж өндөр, баллаар авч үзвэл 1.22-1.36 буюу “сайн” үнэлгээтэй байна.


ЗУРАГ 7. БҮРТГЭХ, ЛАВЛАГАА МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН



Байгууллагаар авч үзвэл УИТЭ, УИИТЭ, ХТС, ХСҮТ, АӨСҮТ-ийн хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 90.0-ээс дээш хувьтай, 80.0-аас доош хувьтай байгууллага байхгүй байна.

Амбулаторын үйлчлүүлэгчдийн хувьд ЭХЭМҮТ, ГССҮТ-ийн үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин ойролцоо түвшинд 72.6-72.8%-тай байгаа нь хамгийн бага үзүүлэлт болж байна.

ЗУРАГ 8. БҮРТГЭХ, ЛАВЛАГАА МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ




Бүртгэх, лавлагаа мэдээлэл өгөх үйлчилгээний соёлын сэтгэл ханамжийн үнэлгээгээр хэвтэн эмчлүүлэгчдийн 79.4% нь, амбулаторын үйлчлүүлэгчдийн 69.8% нь сайн гэж үнэлсэн бол $25.4 \pm 4.8\%$ нь сэтгэл ханамжгүй байна.

Байгууллагаар авч үзвэл УИИТЭ, ХСҮТ-ийн хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамж өндөр байгаа бол, ХӨСҮТ, ГССҮТ нь 70.0-аас доош хувьтай, ЭХЭМҮТ, ГССҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж 60.0-аас доош хувьтай байна.


Байгууллагын ажилтны хувцаслалтын соёл буюу нэгдсэн загвар бүхий хувцаслалт, энгэрийн тэмдэгийн талаар хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 94.6%, амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 90.0%-тай, 4.6%-иар зөрүүтэй, баллаар авч үзвэл 1.11-1.20 буюу “сайн” үнэлгээтэй байна.

ЗУРАГ 9. АЖИЛТНЫ ХУВЦАСЛАЛТЫН СОЁЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН



Байгууллагаар авч үзвэл ГССҮТ-өөс бусад бүх байгууллагын хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 90.0-ээс дээш хувьтай, амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 85.0-аас дээш хувьтай, сэтгэл ханамж сайн байна.

ЗУРАГ 10. АЖИЛТНЫ ХУВЦАСЛАЛТЫН СОЁЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ




Хувцаслалтын соёлын сэтгэл ханамжийн үнэлгээгээр хэвтэн эмчлүүлэгчдийн 89.9% нь, амбулаторын үйлчлүүлэгчдийн 81.5% нь сайн гэж үнэлсэн бол 14.3 ± 4.2% нь сэтгэл ханамжгүй байна.

Байгууллагаар авч үзвэл УИТЭ, УИИТЭ, ЭХЭМҮТ, СЭМҮТ, ХСҮТ, ХТС-ийн хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамж 90.0-ээс дээш хувьтай, УИИТЭ-ийн амбулаторын үйлчлүүлэгчийн 71.9% нь сайн гэж үнэлгээ өгсөн нь хамгийн бага үзүүлэлт болж байна.

2.3. Байгууллагын дотоод, гадаад орчны тав тух


Байгууллагын дотоод орчны соёл, тав тухтай байдалд хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 90.0%, амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 81.9%-тай, 8.1%-ийн зөрүүтэй, баллаар авч үзвэл 1.20-1.36 буюу “сайн” үнэлгээтэй байна.

ЗУРАГ 11. БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ОРЧНЫ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН



Байгууллагаар, дотоод орчны тав тухтай байдалд ХТС, СЭМҮТ, УИИТЭ, ХСҮТ-ийн хэрэглэгчдийн сэтгэл ханамж 90.0-ээс дээш хувьтай байна. Амбулаторын үйлчлүүлэгчдийн хувьд ГССҮТ-ийн сэтгэл ханамжийн түвшин хамгийн (64.8) бага хувьтай, сэтгэл ханамжийн түвшин “дунд” байна.

ЗУРАГ 12. БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ОРЧНЫ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ




ЭМСЯ-НЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

Байгууллагын дотоод орчны соёл, тав тухтай байдалд хэвтэн эмчлүүлэгчдийн 81.4% нь, амбулаторын үйлчлүүлэгчдийн 67.9% нь сайн гэж үнэлсэн бол $25.3 \pm 6.8\%$ нь сэтгэл ханамжгүй, ялангуяа амбулаторын үйлчлүүлэгчдийн 32.1% нь дунд, муу гэж үнэлжээ. Байгууллагаар авч үзвэл ХТС, СЭМҮТ-ийн хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамж хамгийн өндөр, УИИТЭ, ГССҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж бага байна.


Байгууллагын үзлэг, оношилгооны өрөөнүүдийн хаягжилтад хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 94.5%, амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 89.2%-тай, 5.3%-ийн зөрүүтэй, баллаар авч үзвэл 1.11-1.22 буюу “сайн” үнэлгээтэй байна.

ЗУРАГ 13. БАЙГУУЛЛАГЫН ҮЗЛЭГ, ОНОШИЛГООНЫ ӨРӨӨНИЙ ХАЯГЖИЛТЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН



Үзлэг, оношилгооны өрөөний хаягжилтад дийлэнх байгууллагын буюу УИТЭ, УИИТЭ, УИИТЭ, ХӨСҮТ, АӨСҮТ, ГҮТ, ХТС, СЭМҮТ, УИИТЭ, ХСҮТ-ийн хэрэглэгчдийн сэтгэл ханамж 90.0-ээс дээш хувьтай байна. Амбулаторын үйлчлүүлэгчдийн хувьд ГССҮТ-ийн сэтгэл ханамжийн түвшин хамгийн (71.1) бага байна.


ЗУРАГ 14. БАЙГУУЛЛАГЫН ҮЗЛЭГ, ОНОШИЛГООНЫ ӨРӨӨНИЙ ХАЯГЖИЛТЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ



Байгууллагын үзлэг, оношилгооны өрөөний хаягжилтад хэвтэн эмчлүүлэгчдийн 89.7% нь, амбулаторын үйлчлүүлэгчдийн 80.5% нь сайн гэж үнэлсэн бол $14.9 \pm 4.6\%$ нь сэтгэл ханамжгүй байна. Байгууллагаар авч үзвэл УИТЭ, ЭХЭМҮТ, ХСҮТ, ГҮТ, СЭМҮТ-ийн хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамж 90.0-ээс дээш хувьтай байгаа бол, ГССҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж бага, 54.4%-тай байна.


Байгууллагын гадаад орчны тохижилтод хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 77.6%, амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 73.6%-тай, 4.0%-ийн зөрүүтэй, баллаар авч үзвэл 1.45-1.53 буюу “сайн” үнэлгээтэй байна.

ЗУРАГ 15. БАЙГУУЛЛАГЫН ГАДААД ОРЧНЫ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН



Байгууллагаар авч үзвэл СЭМҮТ, ХСҮТ-ийн хэвтэн эмчлүүлэгчид сэтгэл ханамж өндөр, ХӨСҮТ, ГССҮТ-ийн хувьд 70.0-аас доош хувьтай байна. Амбулаторын үйлчлүүлэгчдийн хувьд ГССҮТ-ийн сэтгэл ханамжийн түвшин (57.6) “дунд” байна.


ЗУРАГ 16. БАЙГУУЛЛАГЫН ГАДААД ОРЧНЫ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ



Байгууллагын гадаад орчны тохиолтод хэвтэн эмчлүүлэгчдийн 61.4% нь, амбулаторын үйлчлүүлэгчдийн 54.4% нь сайн гэж үнэлсэн бол 42.1±3.5% нь буюу сэтгэл ханамжгүй байдал цөөнгүй хувийг эзэлж байна. Байгууллагаар авч үзвэл СЭМҮТ-ийн хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамж хамгийн өндөр байгаа бол, УИИТЭ, ЭХЭМҮТ, ГССҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж хангалтгүй байна.

Байгууллагын машины зогсоолын хүртээмжид хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 69.4%, амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 62.7%-тай, баллаар авч үзвэл 1.81-1.95 буюу сэтгэл ханамж “дунд” байна.


ЗУРАГ 17. БАЙГУУЛЛАГЫН МАШИНЫ ЗОГСООЛЫН ХҮРТЭЭМЖИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН



ЭМСЯ-НЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

Байгууллагаар авч үзвэл СЭМҮТ-д сэтгэл ханамж хамгийн өндөр байгаа бол дийлэнхдээ, тухайлбал УИТЭ, УТШЭ, ЭХЭМҮТ, ХӨСҮТ, ГССҮТ, АӨСҮТ-ийн машины зогсоолын хүртээмж хангалтгүй, сэтгэл ханамжийн түвшин “дунд” байна.

ЗУРАГ 18. БАЙГУУЛЛАГЫН МАШИНЫ ЗОГСООЛЫН ХҮРТЭЭМЖИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ



Байгууллагын машины зогсоолын хүртээмжид хэвтэн эмчлүүлэгчдийн 41.0% нь, амбулаторын үйлчлүүлэгчдийн 34.6% нь сайн гэсэн бол дийлэнх нь “дунд”, “муу” гэж үнэлэн, сэтгэл ханамжгүй байгаагаа илэрхийлсэн байна.

Байгууллагаар авч үзвэл СЭМҮТ-ийн хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамж хамгийн өндөр, бусад эмнэлэг, төвүүдийн дийлэнх нь сэтгэл ханамжгүй, дунд, муу байна.

2.4. Байгууллагын соёлын талаар хэрэглэгчид юуг, ямар байхыг хүсэв

Нээлттэй асуулгаар, дийлэнх хэрэглэгчид тав тухтай, эрүүл ахуйн шаардлагыг дээд зэргээр хангасан, цэвэрхэн орчинд үйлчилгээ авахыг хүсч байна.

Амбулаторын үйлчилгээний угтах үйлчилгээг сайжруулах, мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийдэг мэргэжилтэнтэй байх, хоол судлал, сэтгэл зүйн мэргэжилтэн ажлуулан, зөвлөгөө өгүүлдэг болох, хүнд өвчтэй, сэхээнд байгаа хүний ар гэрийнхэнд сэтгэл зүйн зөвлөгөө өгдөг, мэдээлэл сайн өгдөг байхыг хүсэж байна.

Дотоод орчны тав тухыг сайжруулахын тулд хамгийн түрүүнд эмнэлэг өөрийн бие засах газрын асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй гэдэгтэй олон үйлчлүүлэгч санал нэгдсэн байна.

Нилээдгүй тохиолдолд эмнэлэгт орж ирэнгүүт бие засах газрын үнэр үнэртдэг, агааржуулалт байхгүй, хүлээлгийн сандлын тоо цөөхөн, эвдэрхий, суух газар олдоггүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэд ая тухтай үйлчлүүлэх боломж бага, өрөөний халаалт муугаас даарч, өвчин сэдэрэх тохиолдол гардаг гэжээ.

Эмнэлгийн ор, дэвсгэр, дэрний уут эрүүл ахуйн шаардлага хангаагүй, хоолны чанар муу, коридорт шүүлтүүрийн халуун, хүйтэн цэвэр усгүйгээс эм уух ус олдохгүй хүндрэл учирдаг байна. Мөн эмнэлэгт үйл ажиллагаа явуулж буй үйлчилгээний, тухайлбал буфет, кофе үйлчилгээний газрын үнэ өндөр, өвчтэй хүмүүст тохирсон хоол, цайгаар үйлчилдэггүй байна.

Тусламж, үйлчилгээний онцлогоос хамааран ГССҮТ-ийн үйлчлүүлэгчид тухайн эмнэлэг нь гэр оронгүй, гудамжны, архи уусан хүмүүсийн гэр орон болсоныг өгүүлж байна.

Орон гэргүй хүмүүс олноор ирж хоног төөрүүлж байгаа нь энэ эмнэлгийн ачааллыг ихээхэн нэмж, стресс ихтэй сэтгэл зүйн орчинд ажиллаж байгаа эмч, сувилагч, өвчтөнд асар их төвөг учруулж байгааг таслан зогсоох хэрэгтэй, энэ асуудлыг шийдэж өгөхийг хүсэж байна.

Эмнэлгийн гадаад орчны тохиолт, гэрэлтүүлгийг сайжруулах, ялангуяа машины зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлэх талаар дийлэнх нь санал хэлсэн байна.

Асуудал 1. Жорлонд аяга угаадаг, маш тохиромжгүй байна. 00 өрөө дэндүү давчуу, хаалга нь нүүрэнд хүрэх шахам, тав тухгүй. Нийтийн 00 маш бохир, үнэрийг арилгаач гэхээр угаасаа үнэртээд байдгын гэх юм. Эмнэлэгт оронгуут бохирын үнэр гарахаар ямар байхав... Хүнд өвчтөнтэй сахиуруудын тохь тухыг анхаарахыг хүсэж байна.

Асуудал2. Коридор хүйтэн, гэрэлтүүлэг, тохижилт муу байна, Эвдэрхий сандал, залгуур их байна. Халаалт муу учир өвчтөн эргээд өвчин тусч байна. Wi-fi интернет үйлчилгээтэй байвал зүүээр, нийтийн үзельтэй бол сайхан,. Хоолны цэсийг самбарт хадаж байвал зүүээр. Цэвэрлэгээ сайн хийх, хөнжил гудсаа угаах, ариутгах хэрэгтэй байна.


Асуудал 3. Эмнэлгийн ачаалал дэндүү их байна. Угтах үйлчилгээ муу байна Хүлээн авах тасагт орон гэргүй хүмүүс маш их, эмнэлэгт хоног төөрүүлдэг юм байна. Эмч, сувиллагч, асрагч нарыг доромжилж байна. Гудамжны согтуу хүмүүс бүх хүмүүст төвөг учруулж байна. Энийг таслан зогсоож өгөөч. Цагдаа ажлаа хийхгүй байна.

БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Байгууллагын соёлыг үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдал, үйлчилгээний соёл, дотоод гадаад орчны тав тух гэсэн 3 дэд бүлгийн хүрээнд 9 хэмжигдэхүүнээр судлав. Хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 85.3%, амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 79.5%-тай, баллаар авч үзвэл 1.29-1.41 буюу сэтгэл ханамж “сайн” байна.

Нийтлэгээр байгууллагын соёлд хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамж, амбулаторын үйлчлүүлэгчдээс тогтмол өндөр байна.

ЗУРАГ 19. БАЙГУУЛЛАГЫН СОЁЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН



Байгууллагаар авч үзвэл ХСҮТ, СЭМҮТ, УИИТЭ, ХТС-ийн хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 90.0-ээс дээш хувьтай, сэтгэл ханамжийн түвшин өндөр байна.

ГССҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 65.0%тай, “дунд” үнэлгээтэй байна.

ЭМСЯ-НЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

Байгууллагын машины зогсоолын хүртээмжид хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшин нийтлэгээр хангалтгүй, “дунд” үнэлгээтэй байна.

ГССҮТ нь байгууллагын соёлын 9 хэмжигдэхүүний 5 үзүүлэлтэд сэтгэл ханамжийн түвшингээр “дунд” гэсэн үнэлгээ авсан нь хангалтгүй үзүүлэлт болж байна.

Нээлттэй асуулгаар хэрэглэгчид тав тухтай, угтах үйлчилгээтэй, цэвэрхэн бие засах газартай, цэвэрлэгээ үйлчилгээ сайтай, шүүлтүүрийн халуун, хүйтэн устай, машины зогсоол нь хүртээмжтэй байхыг хамгийн их хүсэж байна.


БҮЛЭГ 3. ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛ

Судалгаанд эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёлыг эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эмч, сувилагч, асаргаа үйлчилгээний ажилтаны харилцаа ёс зүйг хамааруулсан 6-7 хэмжигдэхүүнээр тодорхойлсон.

3.1. Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй


Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйд хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 92.6%-тай, амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 84.0%-тай, хэвтэн эмчлүүлэгчид амбулаторын үйлчлүүлэгчдээс 8.6-иар сэтгэл ханамж өндөр, баллаар авч үзвэл 1.15-1.32 буюу “сайн” үнэлгээтэй байна.

ЗУРАГ 20. ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН



Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн сэтгэл ханамжийн түвшинг байгууллагаар авч үзвэл хэвтэн эмчлүүлэгчийн сэтгэл ханамж тогтмол өндөр, ГССҮТ, ХӨСҮТ-ээс бусад байгууллага 90.0-ээс дээш хувьтай байна. ЭХЭМҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 75.6% байгаа нь хамгийн бага үзүүлэлт болж байна.


ЗУРАГ 21. ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ



Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг хэвтэн эмчлүүлэгчдийн 85.7% нь, амбулаторын үйлчлүүлэгчдийн 70.9% нь сайн гэж үнэлсэн бол 21.7 ± 7.4 % нь сэтгэл ханамжгүй, дунд муу гэж үнэлжээ. Байгууллагаар, ХСҮТ, УИТЭ, УИИТЭ-ийн хэвтэн эмчлүүлэгчид сэтгэл ханамж өндөртэй, УИТЭ, УИИТЭ, ЭХЭМҮТ, ХӨСҮТ, ГССҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн 30 гаран хувь нь сэтгэл ханамжгүй байна.


Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн нэг бүрэлдэхүүн хэсэг болох *үйлчлүүлэгчийн нууц хадгалалтад* хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 91.5%-тай, амбулаторынх 87.4%-тай, 4.1%-ийн зөрүүтэй, баллаар авч үзвэл 1.17-1.25 буюу “сайн” үнэлгээтэй байна.

ЗУРАГ 22. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН НУУЦ ХАДГАЛАЛТЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН



Үйлчлүүлэгчийн нууц хадгалалтын сэтгэл ханамжийн түвшинг байгууллагаар авч үзвэл УИТЭ, УИИТЭ, ЭХЭМҮТ, СЭМҮТ, ХСҮТ, ГҮТ, АӨСҮТ-ийн хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 90.0-ээс дээш хувьтай, үйлчлүүлэгчид өөрсдийнхөө нууцыг хадгалдаг гэдэгт итгэж, сайн үнэлгээ өгсөн байна.

ЗУРАГ 23. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН НУУЦ ХАДГАЛАЛТЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ




Үйлчлүүлэгчийн нууц хадгалалтын сэтгэл ханамжийн үнэлгээгээр хэвтэн эмчлүүлэгчдийн 84.3% нь, амбулаторын үйлчлүүлэгчдийн 76.7% нь сайн гэж үнэлсэн бол 19.5 ± 3.8% нь сэтгэл ханамжгүй байна.

Байгууллагаар авч үзвэл УИИТЭ, ХСҮТ-ийн хэвтэн эмчлүүлэгчид, ГҮТ, СЭМҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин өндөр байгаа бол, ХӨСҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж 68.2%-тай байгаа нь хамгийн бага үзүүлэлт юм.

3.2. Эмчийн харилцаа, үйлчилгээний соёл


Эмчийн угтах, мэндлэх, найрсаг, харилцаа, үйлчилгээний соёлд хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 91.1%-тай, амбулаторынх 83.3%-тай, хэвтэн эмчлүүлэгчид амбулаторын үйлчлүүлэгчдээс 7.8-иар өндөр, баллаар авч үзвэл 1.15-1.32 буюу “сайн” үнэлгээтэй байна.

ЗУРАГ 24. ЭМЧИЙН ХАРИЛЦАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН



Байгууллагаар, ГССҮТ, ХӨСҮТ-ээс бусад байгууллагын хэвтэн эмчлүүлэгчийн сэтгэл ханамж 90.0-ээс дээш хувьтай байна. ЭХЭМҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 73.1% байгаа нь хамгийн бага үзүүлэлт юм.

ЗУРАГ 25. ЭМЧИЙН ХАРИЛЦАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ




Эмчийн утгах, мэндлэх, найрсаг харилцаа, үйлчилгээний соёлыг хэвтэн эмчлүүлэгчдийн 83.7% нь, амбулаторын үйлчлүүлэгчдийн 70.7% нь сайн гэж үнэлсэн ба ханамжгүй байдал $22.8 \pm 6.5\%$ -тай байна. Амбулаторын үйлчлүүлэгчдийн 29.3% нь сэтгэл ханамжгүй байна.

Байгууллагаар авч үзвэл УИТЭ, УИТЭ, ХСҮТ-ийн хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамж өндөр, УИТЭ, ЭХЭМҮТ, ГССҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж 65.0-аас доош хувьтай байна.


Эмчийн харилцааны ур чадварын бүрэлдэхүүн хэсэг болох сонсох, зөвлөгөө өгөх ур чадварт хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 93.3%-тай, амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 85.9%-тай, 7.4%-ийн зөрөөтэй, баллаар авч үзвэл 1.13-1.28 буюу “сайн” үнэлгээтэй байна.

ЗУРАГ 26. ЭМЧИЙН СОНСОХ, ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ УР ЧАДВАРЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН



Байгууллагаар авч үзвэл ХӨСҮТ-ээс бусад байгууллагуудын хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 90.0-ээс дээш хувьтай, амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 82.3-100.0% -тай байна.

ЗУРАГ 27. ЭМЧИЙН СОНСОХ, ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ УР ЧАДВАРЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ




Эмчийн сонсох, зөвлөгөө өгөх ур чадварт хэвтэн эмчлүүлэгчдийн 87.1%, амбулаторын үйлчлүүлэгчдийн 74.6% нь сайн гэж үнэлсэн бол 19.1± 6.3% нь сэтгэл ханамжгүй байна.

Байгууллагаар авч үзвэл УИТЭ, УИИТЭ, ХСҮТ, ХТС-ын хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамж өндөр байгаа бол УИИТЭ, ЭХЭМҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн 30 орчим хувь нь сэтгэл ханамжгүй байна.

3.3. “Сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн, үйлчилгээний ажилтны харилцаа, үйлчилгээний соёл


Сувилагч, эмнэлгийн мэргэжилтний угтах, мэндлэх, найрсаг харилцаа, үйлчилгээний соёлд хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 90.0%-тай, амбулаторынх 82.5%-тай, 7.5%-иар зөрөөтэй, баллаар авч үзвэл 1.20-1.35, “сайн” үнэлгээтэй байна.

ЗУРАГ 28. СУВИЛАГЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ХАРИЛЦАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН



Сувилагч, эмнэлгийн мэргэжилтний харилцаа, үйлчилгээний соёлыг байгууллагаар авч үзвэл УИТЭ, УИИТЭ, УИИТЭ, СЭМҮТ, ХСҮТ, ХТС, АӨСҮТ-ийн хэвтэн эмчлүүлэгч, ГҮТ, УИИТЭ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин өндөр, 90.0-ээс дээш хувьтай байна. УИТЭ, ЭХЭМҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 70.3-70.5%-тай байгаа нь хамгийн бага үзүүлэлт юм.

ЗУРАГ 29. СУВИЛАГЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ХАРИЛЦАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ




Сувилагч, эмнэлгийн мэргэжилтний *угтах, мэндлэх, найрсаг харилцаа, үйлчилгээний* соёлд хэвтэн эмчлүүлэгчдийн 87.8%, амбулаторын үйлчлүүлэгчдийн 69.2% нь сайн гэж үнэлсэн бол $24.5 \pm 6.3\%$ нь сэтгэл ханамжгүй байна. Хэвтэн эмчлүүлэгч, амбулаторын үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн зөрөө ихтэй, ялангуяа амбулаторын үйлчлүүлэгчдийн 30.8% нь сэтгэл ханамжгүй байдал харагдаж байна.

Байгууллагаар авч үзвэл УИИТЭ, ХСҮТ, ХТС-ын хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамж өндөр байгаа бол ГССҮТ, ЭХЭМҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн 33.4-40.1% нь сэтгэл ханамжгүй байна.


Сувилагч, эмнэлгийн мэргэжилтний сонсох, зөвлөгөө өгөх үр чадварт хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 91.5%-тай, амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 84.5%-тай, 7.0%-иар зөрөөтэй, баллаар авч үзвэл 1.17-1.31 буюу “сайн” үнэлгээтэй байна.

ЗУРАГ 30. СУВИЛАГЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ СОНСОХ, ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ҮР ЧАДВАРЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН



Сувилагч, эмнэлгийн мэргэжилтний *сонсох, зөвлөгөө өгөх үр чадварыг* байгууллагаар авч үзвэл УИТЭ, УИИТЭ, ЭХЭМҮТ, СЭМҮТ, ХСҮТ, ХТС, АӨСҮТ-ийн хэвтэн эмчлүүлэгч, ГҮТ, УИИТЭ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин өндөр байна. ЭХЭМҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 77.4%-тай байгаа нь хамгийн бага үзүүлэлт болж байна.

ЗУРАГ 31. СУВИЛАГЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ СОНСОХ, ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ҮР ЧАДВАРЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ




ЭМСЯ-НЫ ХАРЬАА БАЙГУУЛЛАГУУДЫН ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

Сувилагч, эмнэлгийн мэргэжилтний сонсох, зөвлөгөө өгөх ур чадварт хэвтэн эмчлүүлэгчдийн 83.7%, амбулаторын үйлчлүүлэгчдийн 72.0% нь сайн гэж үнэлсэн бол $22.1 \pm 5.85\%$ нь сэтгэл ханамжгүй, ялангуяа амбулаторын үйлчлүүлэгчдийн 28% нь сэтгэл ханамжгүй байдал харагдлаа. Байгууллагаар авч үзвэл УИТЭ, УИИТЭ, ХСҮТ, ХТС-ын хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамж өндөр байгаа бол УИИТЭ, ЭХЭМҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн 30 гаран хувь нь сэтгэл ханамжгүй, дийлэнх нь дунд үнэлгээ өгсөн байна.


Асаргаа, үйлчилгээний ажилтны угтах, мэндлэх, найрсаг харилцаа, үйлчилгээний соёлыг зөвхөн хэвтэн эмчлүүлэгчдээр үнэлүүлсэн болно. Судалгаанд оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин 89.9%-тай, баллаар авч үзвэл 1.20 буюу “сайн” үнэлгээтэй байна.

ЗУРАГ 32. АСАРГАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТНЫ ХАРИЛЦАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН



Асаргаа, үйлчилгээний ажилтны угтах, мэндлэх, найрсаг харилцаа, үйлчилгээний соёлыг байгууллагаар авч үзвэл дийлэнх нь 90.0-ээс дээш хувьтай, ХӨСҮТ нь 78.6%-ийн сэтгэл ханамжийн түвшинтэй байгаа нь хамгийн бага үзүүлэлт юм.

ЗУРАГ 33. АСАРГАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТНЫ ХАРИЛЦАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ



Асаргаа, үйлчилгээний ажилтны угтах, мэндлэх, найрсаг харилцаа, үйлчилгээний соёлд хэвтэн эмчлүүлэгчдийн 82.0% нь сайн гэсэн үнэлгээ өгсөн бол 15.2% нь дунд, 2.2% нь муу гэсэн үнэлгээ өгчээ. Байгууллагаар авч үзвэл УИТЭ, УИИТЭ, ХСҮТ-ийн хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамж өндөр, УИИТЭ, ХӨСҮТ, ГССҮТ-ийн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамж 65.4-68.1%-тай, 30 гаран хувь нь сэтгэл ханамжгүй байна.

3.4. Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёлын талаар хэрэглэгчид юуг, ямар байхыг хүсэв.

Судалгаанд хамрагдан санал, хүсэлтээ илэрхийлсэн хэрэглэгчдийн цөөнгүй хэсэг нь эмч, эмнэлгийн мэргэжилтэн, сувилагч, асаргаа, үйлчилгээний ажилтны үйлчилгээ, харилцааны соёлд талархал илэрхийлсэн байхад мөн цөөнгүй хэсэг нь бухимдал илэрхийлсэн байна.

Дийлэнх хэрэглэгчид эмч, эмнэлгийн мэргэжилтнээс, ажилдаа сэтгэлээсээ хандаж, хүнлэг байж, инээмсэглэн угтаж, үзлэг хийхдээ хянамгай, оношилгоо, эмчилгээний талаар сайн зөвлөгөө өгч, бас өөрсдийнхөө санал, бодлыг сонсдог байхыг хүсч байна. Эмч, мэргэжилтэн, үйлчилгээ хариуцсан

ЭМСЯ-НЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

ажилтны найрсаг харилцаа, чин сэтгэл, инээмсэглэл, шуурхай үйлчилгээ нь эерэг энергийг бий болгож, өвчний эдгэрэлтэд ихээхэн нөлөөтэй гэдгийг сануулж байна.

Цахимын бүртгэл мэдээллийн ажилтнууд харилцааны соёлгүй, их зантай, асуудлыг шуурхай шийдвэрлэдэггүй, ажилдаа ур чадвар муутай, удаан ажилладаг талаар ихэнх эмнэлгийн хэрэглэгчид бухимдаж байна. Тухайлбал: Цахим бүртгэл мэдээллийн ажилчид бүртгэл хийхдээ мэндэлдэггүй, компьютерийн мэдлэг, шивэлтийн ур чадвар хангалтгүйгээс удаан ажилладаг, тайлбар зөвлөгөө өгдөггүй, асуухаар уцаартай ханддаг, шуурхай үйл ажиллагаа, найрсаг, инээмсэглэсэн харилцаа дутагдаж байгааг хэлж байна.

Банкны ажилчдын соёл, инээмсэглэл, үйлчилгээнээс жишээ авахыг хүссэн хэрэглэгч ч байна. Эмч, мэргэжилтэн нь ачаалал маш ихтэй ажилладагаас үзлэгээ чанаргүй хийдэг, мөн баахан шинжилгээ хийлгэхийг шаарддаг ч, юуны учир яах гэж хийлгэсэн, хариу нь ямар гарсан, ямар үр дүн, шийдвэрт хүрсэн талаар тайлбар зөвлөгөө бараг өгдөггүй талаар олонхи нь хэлсэн байна.

Эмч нар үзлэг хийхдээ хайнга, чагнуур тавих төдий, тэмтрэх зэрэг гар хүрч үздэггүй, буруу оношилсоноос өвчтөн хохирдог, алдаагаа нуудаг, ёс зүйгүй, асуусан асуултад хариулдаггүй гэсэн байна. Түүнчлэн эмч нарын картан дээр бичсэн оношилгоо, эмчилгээ гаргацгүй, муухай бичдэг, жорыг нь эмийн сан ч уншиж чаддаггүй талаар хөндсөн байна.

Асуудал 4. Өвчтөнтэй найрсаг зөв боловсон харилцан, заавар зөвлөгөө өгмөөр байна. Мэдрэлийн эмч юу ч үзэлгүй шинжилгээ өг гээд асуусан асуултад хариулсангүй. Холоос ирсэн миний хувьд сэтгэл дундуур л байна. Энэ газар биеэ эмчлүүлэх гэж ирсэн боловч найдвар харагдахгүй байна. Харамсалтай байна.

Асуудал 5. Эмч үйлчлүүлэгчидтэй мэндэлдэггүй, уцаартай харилцдаг. Эмчилгээ болон тухайн өвчний талаар тайлбар өгдөггүй, Өвчтөнөө хангалттай үздэггүй, зөвхөн шинжилгээ, картны тэмдэглэл зэрэг цаастай ажилладаг. Бодит үзлэг хангалтгүй, харилцааны соёлгүй зэрэг нь сэтгэл ханамжид нөлөөлдөг. Ард түмэн бухимдалгүй уур уцааргүй, хурдан шуурхай чирэгдэлгүй, очер дараалалгүй, хүртээмжтэй үйлчилгээг л хүсэж байна.


Асуудал 6. Биднийг хараад сайхан инээмсэглэн, мэндэлж байхыг хүсэж байна. Та нарын инээмсэглэлийг хараад бид маш их энерги авч, эдгэнэ. Өвчтөн хүний сэтгэл санаа хямарсан эмзэг байдаг тул нэг эелдэг үг сэтгэл санааг өөдрөг болгохыг санаж эелдэг, инээмсэглэж, зөвлөж үйлчлэхийг хүсэж байна. Баярлалаа

БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ёс зүй, үйлчилгээний соёлыг эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, эмчийн харилцаа, үйлчилгээний соёл, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн, үйлчилгээний ажилтны харилцаа, үйлчилгээний соёл гэсэн 3 дэд бүлгийн хүрээнд 6-7 хэмжигдэхүүнээр амбулатор, хэвтэн эмчлүүлэгчээр харьцуулан судлав.

Нийтлэгээр эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ёс зүй, харилцаа, үйлчилгээний соёлд хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамж, амбулаторын үйлчлүүлэгчдээс тогтмол өндөр байна. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ёс зүй, үйлчилгээний соёлд хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшин сайн байна.

ЗУРАГ 34. ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТЭН, АЖИЛТНЫ ЁС ЗҮЙ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН



ЭМСЯ-НЫ ХАРЬАА БАЙГУУЛЛАГУУДЫН ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

Байгууллагаар, ерөнхий дүнгээр авч үзвэл, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ёс зүй, үйлчилгээний соёлд УИТЭ, УИИТЭ, ЭХЭМҮТ, СЭМҮТ, ХСҮТ, АӨСҮТ, ХТС-ийн хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 90.0-ээс дээш хувьтай, сэтгэл ханамж өндөр байна. Эмчийн харилцаа, үйлчилгээний соёлд УИТЭ, ЭХЭМҮТ, ГССҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж 35.0 орчим хувь нь, сонсох, зөвлөгөө өгөх ур чадварт УИИТЭ, ЭХЭМҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн 30 орчим хувь нь сэтгэл ханамжгүй байна. Сувилагч, эмнэлгийн мэргэжилтний харилцаа, үйлчилгээний соёлд ГССҮТ, ЭХЭМҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн 33.4-40.1% нь сэтгэл ханамжгүй, сонсох, зөвлөгөө өгөх ур чадварт УИИТЭ, ЭХЭМҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн 30 орчим хувь нь сэтгэл ханамжгүй байна. Асаргаа, үйлчилгээний ажилтны харилцаа, үйлчилгээний соёлд УИИТЭ, ХӨСҮТ, ГССҮТ-ийн эмчлүүлэгчдийн 30 гаран хувь нь сэтгэл ханамжгүй байна. Нээлттэй асуулгаар эмч, эмнэлгийн мэргэжилтнээс, ажилдаа сэтгэлээсээ хандаж, хүнлэг байж, инээмсэглэн угтаж, үзлэг хийхдээ хянамгай, оношилгоо, эмчилгээний талаар сайн зөвлөгөө өгч, бас өөрсдийнхөө санал, бодлыг сонсдог байхыг илүү хүсэж байна.

ХҮСНЭГТ 5. ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН

Эмнэлгийн нэр	2.1. Эмчийн утгах, мэндлэх, найрсаг харилцаа, үйлчлэх соёл		2.2. Сувилагч, эмнэлгийн мэргэжилтний утгах, мэндлэх, найрсаг харилцаа, үйлчлэх соёл		2.3. Эмчийн сонсох, зөвлөгөө өгөх үр чадвар		2.4. Сувилагч, эмнэлгийн мэргэжилтний сонсох, зөвлөгөө өгөх үр чадвар		2.5. Асаргаа, үйлчилгээний ажилтны утгах, мэндлэх, найрсаг харилцаа, үйлчлэх соёл		2.6. Үйлчлүүлэгчийн нууц хадгалалтад итгэх итгэл		2.7. Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй		Бүлгийн дундаж		
	Балл	%	Балл	%	Балл	%	Балл	%	Балл	%	Балл	%	Балл	%	Балл	%	
УИТЭ	ХЭ	1.09	95.7	1.11	94.4	1.09	95.7	1.09	95.7	1.08	95.9	1.12	93.9	1.08	95.9	1.09	95.3
	АҮ	1.40	79.8	1.41	79.3	1.34	83.0	1.38	81.1	1.38	81.1	1.27	86.7	1.39	80.5	1.37	81.7
УИТЭ	ХЭ	1.05	97.3	1.06	96.9	1.04	98.1	1.03	98.5	1.05	97.7	1.03	98.5	1.05	97.7	1.04	97.8
	АҮ	1.15	92.7	1.12	93.8	1.17	91.4	1.15	92.5	1.15	92.5	1.16	92.2	1.13	93.3	1.15	92.6
УИПЭ	ХЭ	1.18	90.8	1.19	90.6	1.13	93.5	1.22	89.1	1.34	82.9	1.24	87.9	1.17	91.5	1.21	89.5
	АҮ	1.34	82.9	1.34	83.1	1.33	83.3	1.35	82.4	1.35	82.4	1.30	84.9	1.40	80.2	1.34	82.8
ЭХЭМҮТ	ХЭ	1.20	90.0	1.26	87.1	1.13	93.3	1.18	91.1	1.20	90.2	1.14	92.8	1.16	92.2	1.18	91.0
	АҮ	1.54	73.1	1.59	70.5	1.35	82.3	1.45	77.4	1.43	78.6	1.37	81.5	1.49	75.6	1.47	76.7
ХӨСҮТ	ХЭ	1.32	83.9	1.33	83.6	1.31	84.6	1.28	85.9	1.43	78.6	1.31	84.6	1.25	87.4	1.31	84.4
	АҮ	1.34	83.1	1.40	80.1	1.34	82.8	1.31	84.6	1.31	84.6	1.36	81.8	1.40	79.9	1.36	82.1
СЭМҮТ	ХЭ	1.23	88.5	1.15	92.3	1.15	92.3	1.12	94.2	1.12	94.2	1.15	92.3	1.19	90.4	1.16	92.0
	АҮ	1.17	91.7	1.22	88.9	1.11	94.4	1.17	91.7	1.17	91.7	1.06	97.2	1.17	91.7	1.15	92.6
ГССҮТ	ХЭ	1.32	83.9	1.38	80.8	1.17	91.6	1.30	84.8	1.38	81.0	1.23	88.6	1.23	88.6	1.28	85.9
	АҮ	1.40	79.9	1.44	78.0	1.23	88.3	1.33	83.3	1.33	83.3	1.35	82.4	1.37	81.5	1.36	82.2
ХСҮТ	ХЭ	1.03	98.6	1.02	98.9	1.02	98.9	1.05	97.5	1.02	99.2	1.02	98.9	1.02	98.9	1.03	98.7
	АҮ	1.25	87.7	1.31	84.3	1.25	87.4	1.27	86.7	1.27	86.7	1.14	92.9	1.24	88.2	1.24	87.9
АӨСҮТ	ХЭ	1.11	94.5	1.17	91.6	1.10	95.0	1.15	92.4	1.20	90.2	1.15	92.7	1.14	92.9	1.14	92.8
	АҮ	1.28	86.2	1.25	87.4	1.26	86.8	1.24	88.0	1.24	88.0	1.18	91.0	1.17	91.4	1.23	88.5
ХТС	ХЭ	1.07	96.6	1.05	97.7	1.09	95.5	1.09	95.5	1.14	93.2	1.26	87.2	1.11	94.3	1.11	94.4
	АҮ	1.00	100.0	1.04	98.1	1.00	100.0	1.02	99.1	1.00	100.0	1.00	100.0	1.02	99.1	1.01	99.4
Дундаж	ХЭ	1.18	91.1	1.20	90.0	1.13	93.3	1.17	91.5	1.20	89.9	1.17	91.5	1.15	92.6	1.17	91.4
	АҮ	1.33	83.3	1.35	82.5	1.28	85.9	1.31	84.5	1.31	84.5	1.25	87.4	1.32	84.0	1.31	84.6

ХҮСНЭГТ 6. ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ

Эмнэлгийн нэр	2.1. Эмчийн утгах, мэндлэх, найрсаг харилцаа, үйлчлэх соёл				2.2. Сувилагч, эмнэлгийн мэргэжилтний утгах, мэндлэх, найрсаг харилцаа, үйлчлэх соёл				2.3. Эмчийн сонсох, зөвлөгөө өгөх ур чадвар				2.4. Сувилагч, эмнэлгийн мэргэжилтний сонсох, зөвлөгөө өгөх ур чадвар				2.5. Асаргаа, үйлчилгээний ажилтны утгах, мэндлэх, найрсаг харилцаа, үйлчлэх соёл				2.6. Үйлчлүүлэгчийн нууц хадгалалтад итгэх итгэл				2.7. Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй								
	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу	Сайн	Дунд	Муу			
УПЭ	ХЭ 92.3	6.8	0.9	89.2	10.4	0.5	91.4	8.6	0.0	91.4	8.6	0.0	92.3	7.2	0.5	88.7	10.4	0.9	92.3	7.2	0.5	88.7	10.4	0.9	92.3	7.2	0.5	88.7	10.4	0.9	92.3	7.2	0.5
УИПЭ	АУ 65.0	29.6	5.4	64.3	30.0	5.7	71.0	23.9	5.1	66.3	29.6	4.0	96.2	2.3	1.5	94.7	4.6	0.8	96.2	2.3	1.5	94.7	4.6	0.8	96.2	2.3	1.5	94.7	4.6	0.8	96.2	2.3	1.5
УИШЭ	АУ 86.6	12.4	1.1	88.7	10.2	1.1	83.3	16.1	0.5	85.5	14.0	0.5	87.0	13.0	1.9	83.1	15.0	1.9	87.0	13.0	1.9	83.1	15.0	1.9	87.0	13.0	1.9	83.1	15.0	1.9	87.0	13.0	1.9
ЭХЭМҮТ	АУ 69.4	26.9	3.7	69.8	26.4	3.7	69.8	26.9	3.3	69.0	26.9	4.1	82.3	15.3	2.4	77.8	18.5	3.6	82.3	15.3	2.4	77.8	18.5	3.6	82.3	15.3	2.4	77.8	18.5	3.6	82.3	15.3	2.4
ХӨСҮТ	АУ 55.2	35.8	9.1	50.4	40.1	9.5	69.4	25.9	4.7	60.8	33.2	6.0	70.1	25.4	4.4	70.1	25.4	4.4	70.1	25.4	4.4	70.1	25.4	4.4	70.1	25.4	4.4	70.1	25.4	4.4	70.1	25.4	4.4
СЭМҮТ	ХЭ 78.8	19.2	1.9	86.5	11.5	1.9	84.6	15.4	0.0	88.5	11.5	0.0	88.9	11.1	0.0	88.9	11.1	0.0	88.9	11.1	0.0	88.9	11.1	0.0	88.9	11.1	0.0	88.9	11.1	0.0	88.9	11.1	0.0
ГССҮТ	АУ 70.4	27.1	2.5	66.2	29.2	4.6	84.3	14.7	1.0	72.1	25.4	2.5	80.0	16.7	3.3	71.0	24.7	4.3	80.0	16.7	3.3	71.0	24.7	4.3	80.0	16.7	3.3	71.0	24.7	4.3	80.0	16.7	3.3
ХСҮТ	АУ 97.1	2.9	0.0	97.9	2.1	0.0	97.8	2.2	0.0	95.0	5.0	0.0	97.8	2.2	0.0	97.8	2.2	0.0	97.8	2.2	0.0	97.8	2.2	0.0	97.8	2.2	0.0	97.8	2.2	0.0	97.8	2.2	0.0
АӨСҮТ	АУ 77.5	20.3	2.2	72.3	24.1	3.6	74.8	25.2	0.0	75.0	23.5	1.5	89.9	10.1	0.8	89.9	10.1	0.8	89.9	10.1	0.8	89.9	10.1	0.8	89.9	10.1	0.8	89.9	10.1	0.8	89.9	10.1	0.8
ХТС	АУ 74.2	23.9	1.8	75.5	23.9	0.6	74.8	23.9	1.2	76.5	22.8	0.6	90.9	9.1	0.0	90.9	9.1	0.0	90.9	9.1	0.0	90.9	9.1	0.0	90.9	9.1	0.0	90.9	9.1	0.0	90.9	9.1	0.0
ГҮТ	АУ 93.2	6.8	0.0	95.5	4.5	0.0	100.0	0.0	0.0	98.1	1.9	0.0	100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0	100.0	0.0	0.0
Дундаж	ХЭ 83.7	14.7	1.6	81.8	16.4	1.8	87.1	12.4	0.6	83.7	15.5	0.8	87.1	12.4	0.6	83.7	15.5	0.8	87.1	12.4	0.6	83.7	15.5	0.8	87.1	12.4	0.6	83.7	15.5	0.8	87.1	12.4	0.6
	АУ 70.7	25.2	4.1	69.2	26.5	4.3	74.6	22.5	2.9	72.0	24.9	3.0	74.6	22.5	2.9	72.0	24.9	3.0	74.6	22.5	2.9	72.0	24.9	3.0	74.6	22.5	2.9	72.0	24.9	3.0	74.6	22.5	2.9


БҮЛЭГ 4. ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Судалгаагаар эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын хариуцлага, шуурхай байдал, оношилгоо, эмчилгээ, сувилахуй, халдвар хамгаалал, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн чанар, аюулгүй байдлыг хамааруулсан 11-13 хэмжигдэхүүнээр эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг тодорхойлсон.

4.1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал


Эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын хариуцлага, шуурхай байдлын талаар хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 91.8%-тай, амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 80.8%-тай, хэвтэн эмчлүүлэгчид амбулаторын үйлчлүүлэгчдээс 11.0-иар сэтгэл ханамжийн түвшин өндөр, баллаар авч үзвэл 1.16-1.38 буюу “сайн” үнэлгээтэй байна.

ЗУРАГ 35. ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ АЖЛЫН ХАРИУЦЛАГА, ШУУРХАЙ БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН



Сэтгэл ханамжийн түвшинг байгууллагаар авч үзвэл хэвтэн эмчлүүлэгчийн сэтгэл ханамж тогтмол өндөр, ГССҮТ, ХӨСҮТ-ээс бусад байгууллага 90.0-ээс дээш хувьтай байна. ЭХЭМҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 73.5% байгаа нь хамгийн бага үзүүлэлт юм.


ЗУРАГ 36. ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ АЖЛЫН ХАРИУЦЛАГА, ШУУРХАЙ БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ



Эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын хариуцлага, шуурхай байдлыг хэвтэн эмчлүүлэгчдийн 84.1% нь, амбулаторын үйлчлүүлэгчдийн 65.4% нь сайн гэсэн ба цөөнгүй хувиар (18.7%) зөрөөтэй, ялангуяа амбулаторын үйлчлүүлэгчдийн 30.8% нь дунд, 3.8% нь муу гэсэн үнэлгээ өгчээ. Байгууллагаар авч үзвэл ХСҮТ, УИТЭ, ХТС, УИИТЭ-ийн хэвтэн эмчлүүлэгчид сэтгэл ханамж өндөр байгаа бол УИТЭ, УИИТЭ, ЭХЭМҮТ, ХӨСҮТ, ХСҮТ, АӨСҮТ, ГССҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн 33.4-47.4% нь сэтгэл ханамжгүй байгаагаа илэрхийлсэн байна.


Оношилгооны чанар, аюулгүй байдлын талаар хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 92.7%-тай, амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 85.8%-тай, 6.9%-ийн зөрүүтэй, баллаар авч үзвэл 1.15-1.28 буюу “сайн” үнэлгээтэй байна.

ЗУРАГ 37. ОНОШИЛГООНЫ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН



Оношилгооны чанар, аюулгүй байдлын сэтгэл ханамжийн түвшинг байгууллагаар авч үзвэл хэвтэн эмчлүүлэгчийн сэтгэл ханамж тогтмол өндөр, ХӨСҮТ-ээс бусад байгууллага 90.0-ээс дээш хувьтай байна. Амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 80.0%-аас дээш байна.


ЗУРАГ 38. ОНОШИЛГООНЫ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ



Оношилгооны чанар, аюулгүй байдлыг хэвтэн эмчлүүлэгчдийн 85.7% нь, амбулаторын үйлчлүүлэгчдийн 73.4% нь сайн гэж үнэлсэн бол 20.3 ± 6.3 % нь сэтгэл ханамжгүй байна. Байгууллагаар авч үзвэл ХСҮТ, СЭМҮТ, УИИТЭ-ийн хэвтэн эмчлүүлэгчид сэтгэл ханамж өндөр байгаа бол УИТЭ, УИИТЭ, ЭХЭМҮТ, ГССҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн 30 гаруй хувь нь сэтгэл ханамжгүй байна.


Эмчилгээний чанар, аюулгүй байдлын талаар хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 91.1%-тай, амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 83.3%-тай, хэвтэн эмчлүүлэгчид амбулаторын үйлчлүүлэгчдээс 7.8-иар өндөр, баллаар авч үзвэл 1.15-1.32 буюу “сайн” үнэлгээтэй байна.

ЗУРАГ 39. ЭМЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН



Эмчилгээний чанар, аюулгүй байдлын сэтгэл ханамжийн түвшинг байгууллагаар авч үзвэл ХӨСҮТ-ээс бусад байгууллагын хэвтэн эмчлүүлэгчийн сэтгэл ханамжийн түвшин 90.0-ээс дээш хувьтай, бүх байгууллагын амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 81.0% -ээс дээш хувьтай байна.

ЗУРАГ 40. ЭМЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ




Эмчилгээний чанар, аюулгүй байдалд хэвтэн эмчлүүлэгчдийн 88.2% нь, амбулаторын үйлчлүүлэгчдийн 74.8% нь сайн гэж үнэлсэн ба $18.5 \pm 6.7\%$ нь сэтгэл ханамжгүй байна. Амбулаторын үйлчлүүлэгчдийн 25.2% нь сэтгэл ханамжгүй байна.

Байгууллагаар авч үзвэл УИТЭ, УИИТЭ, ХТС, СЭМҮТ, ХСҮТ-ийн хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамж өндөр, УИИТЭ, ЭХЭМҮТ, ГССҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн 35.0 орчим хувь нь сэтгэл ханамжгүй байна.

Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын талаар хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 93.0%-тай, амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 84.4%-тай, хэвтэн эмчлүүлэгчид амбулаторын үйлчлүүлэгчдээс 8.6-иар өндөр, баллаар авч үзвэл 1.14-1.31 буюу “сайн” үнэлгээтэй байна.


ЗУРАГ 41. СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН



Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын сэтгэл ханамжийн түвшинг байгууллагаар авч үзвэл УИИТЭ, ХӨСҮТ-ээс бусад байгууллагын хэвтэн эмчлүүлэгчийн сэтгэл ханамжийн түвшин 90.0-ээс дээш хувьтай байна.

ЭХЭМҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 76.3% байгаа нь хамгийн бага үзүүлэлт болж байна.


ЗУРАГ 42. СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ



Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд хэвтэн эмчлүүлэгчдийн 86.5% нь, амбулаторын үйлчлүүлэгчдийн 70.4% нь сайн гэж үнэлсэн ба $21.5 \pm 8.1\%$ нь сэтгэл ханамжгүй байна. Амбулаторын үйлчлүүлэгчдийн 29.6% нь сэтгэл ханамжгүй байна. Байгууллагаар авч үзвэл УИТЭ, УИИТЭ, ХТС, СЭМҮТ, ХСҮТ-ийн хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамж өндөр, УИТЭ, УИИТЭ, ЭХЭМҮТ, ГССҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн 32.0- 44.3 % нь сэтгэл ханамжгүй байна.


Эм олгох, түгээх, тариа хийх үйлдлийн аюулгүй байдлын талаар хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 92.7%-тай, баллаар авч үзвэл 1.15 буюу “сайн” үнэлгээтэй байна.

ЗУРАГ 43. ЭМ ОЛГОХ, ТҮГЭЭХ, ТАРИА ХИЙХ ҮЙЛДЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН



Судалгаанд хамрагдсан байгууллагын эм олгох, түгээх, тариа хийх үйлдлийн аюулгүй байдалд хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 90.5-ээс дээш хувьтай, ХӨСҮТ-ийн сэтгэл ханамжийн түвшин 86.9% байна.

ЗУРАГ 44. ЭМ ОЛГОХ, ТҮГЭЭХ, ТАРИА ХИЙХ ҮЙЛДЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ




Эм олгох, түгээх, тариа хийх үйлдлийн аюулгүй байдалд хэвтэн эмчлүүлэгчдийн 86.2% нь сайн, 13.0% нь дунд, 0.8% нь муу гэсэн үнэлгээ өгсөн байна. Байгууллагаар авч үзвэл УИИТЭ, ХТС, СЭМҮТ, ХСҮТ-ийн хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамж өндөр, 90.0-ээс дээш хувь нь сайн гэсэн бол ХӨСҮТ-ийн эмчлүүлэгчдийн 24.4% нь сэтгэл ханамжгүй байна.

4.2. Эмнэлгийн дэмжих үйлчилгээний чанар, аюулгүй байдал


Эмнэлгийн барилга, байгууламжийн эрүүл ахуй, аюулгүй байдлын талаар хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 80.2%, амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 76.6%-тай, баллаар авч үзвэл 1.40-1.47 буюу “сайн” үнэлгээтэй байна.

ЗУРАГ 45. БАРИЛГА БАЙГУУЛАМЖЫН ЭРҮҮЛ АХУЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН



Эмнэлгийн барилга, байгууламжийн эрүүл ахуй, аюулгүй байдлын сэтгэл ханамжийн түвшинг байгууллагаар авч үзвэл СЭМҮТ, ХСҮТ хамгийн өндөр хувьтай байна. ГССҮТ-ийн хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшин дунд байна.

ЗУРАГ 46. БАРИЛГА БАЙГУУЛАМЖЫН ЭРҮҮЛ АХУЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ




Эмнэлгийн барилга, байгууламжийн эрүүл ахуй, аюулгүй байдалд хэвтэн эмчлүүлэгчдийн 65.8% нь, амбулаторын үйлчлүүлэгчдийн 58.8% нь сайн гэсэн бол цөөнгүй хувь нь буюу 37.7±3.5% нь сэтгэл ханамжгүй байна. Амбулаторын барилгын эрүүл ахуй, аюулгүй байдалд үйлчлүүлэгчдийн 41.2% нь сэтгэл ханамжгүй байна.

Байгууллагаар авч үзвэл СЭМҮТ, ХСҮТ-өөс бусад байгууллагуудын сэтгэл ханамжийн үнэлгээ 80.0-аас доош хувьтай, ГССҮТ-ийн үйлчлүүлэгчдийн 38.7% нь дунджаар сэтгэл ханамжгүй, ялангуяа амбулаторын барилга байгууламжийн эрүүл ахуйн аюулгүй байдалд 32.6% нь сайн, 41.9% нь дунд, 25.6% нь муу гэсэн үнэлгээ өгчээ.


Эмнэлгийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдалд хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 82.8%, амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 79.0%-тай, баллаар авч үзвэл 1.34-1.42 буюу “сайн” үнэлгээтэй байна.

ЗУРАГ 47. ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН



Эмнэлгийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдлын сэтгэл ханамжийн түвшинг байгууллагаар авч үзвэл УИТЭ, СЭМҮТ, ХСҮТ, ГҮТ өндөр хувьтай байна. ГССҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин дунд байна.


ЗУРАГ 48. ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ



Эмнэлгийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдалд хэвтэн эмчлүүлэгчдийн 69.5% нь, амбулаторын үйлчлүүлэгчдийн 63.5% нь сайн гэж үнэлсэн бол, $33.5 \pm 3.0\%$ нь сэтгэл ханамжгүй байна. Амбулаторын тоног төхөөрөмжийн аюулгүй байдалд үйлчлүүлэгчдийн 36.5% нь итгэл муутай байна. Байгууллагаар авч үзвэл СЭМҮТ, ХСҮТ-өөс бусад байгууллагуудын сэтгэл ханамжийн үнэлгээ 80.0-аас доош хувьтай, ЭХЭМҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн 53.4% нь, ГССҮТ-ийн үйлчлүүлэгчдийн 59.0% нь сэтгэл ханамжгүй байна.


Асаргаатай, хүнд өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх үйлчилгээний аюулгүй байдлын талаар хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 85.0%, амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 77.2%-тай, баллаар авч үзвэл 1.30-1.46 буюу “сайн” үнэлгээтэй байна.

ЗУРАГ 49. АСАРГААТАЙ, ХҮНД ӨВЧТЭЙ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН



Сэтгэл ханамжийн түвшинг байгууллагаар авч үзвэл УИТЭ, УИИТЭ, СЭМҮТ, ХСҮТ, ГҮТ өндөр хувьтай байна. ГССҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин дунд байна.

ЗУРАГ 50. АСАРГААТАЙ, ХҮНД ӨВЧТЭЙ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ




Асаргаатай, хүнд өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх үйлчилгээний аюулгүй байдалд хэвтэн эмчлүүлэгчдийн 73.6% нь, амбулаторын үйлчлүүлэгчдийн 60.1% нь сайн гэж үнэлсэн бол, $33.1 \pm 6.7\%$ нь сэтгэл ханамжгүй байна. Асаргаатай, хүнд өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх үйлчилгээний аюулгүй байдалд үйлчлүүлэгчдийн 39.9% нь сэтгэл ханамжгүй байна.

Байгууллагаар авч үзвэл ХСҮТ-ийн хэвтэн эмчлүүлэгчид 91.4% нь сайн гэсэн нь хамгийн өндөр үзүүлэлт юм. ГССҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн 37.8% нь сайн, 46.7% нь дунд, 15.5% нь муу гэсэн үнэлгээ өгчээ. Мөн УИИТЭ, ЭХЭМҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн 47.6-55.6% нь сэтгэл ханамжгүй байна.


Эмнэлгийн халаалтын систем, усан хангамжийн хүрэлцээний талаар хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 87.3%, амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 80.7%-тай, баллаар авч үзвэл 1.25-1.39 буюу “сайн” үнэлгээтэй байна.

ЗУРАГ 51. ЭМНЭЛГИЙН ХАЛААЛТЫН СИСТЕМ, УСАН ХАНГАМЖИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН



Эмнэлгийн халаалтын систем, усан хангамжийн хүрэлцээний талаарх сэтгэл ханамжийн түвшинг байгууллагаар авч үзвэл УИТЭ, ХСҮТ, ХТС, ГҮТ өндөр хувьтай байна. ГССҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин “дунд” үнэлгээтэй байна.

ЗУРАГ 52. ЭМНЭЛГИЙН ХАЛААЛТЫН СИСТЕМ, УСАН ХАНГАМЖИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ




ЭМСЯ-НЫ ХАРЬАА БАЙГУУЛЛАГУУДЫН ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

Эмнэлгийн халаалтын систем, усан хангамжийн хүрэлцээг хэвтэн эмчлүүлэгчдийн 78.0% нь, амбулаторын үйлчлүүлэгчдийн 65.0% нь сайн гэж үнэлсэн бол, $28.1 \pm 6.1\%$ нь сэтгэл ханамжгүй байна. Амбулаторын халаалтын систем, усан хангамжийн хүрэлцээнд үйлчлүүлэгчдийн 34.2% нь сэтгэл ханамжгүй байна. Байгууллагаар авч үзвэл УИТЭ, СЭМҮТ, ХТС, ХСҮТ-ийн хэвтэн эмчлүүлэгч сэтгэл ханамж өндөр, бусад байгууллагуудын сэтгэл ханамжийн үнэлгээ 88.7-оос доош хувьтай байна. ЭХЭМҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн 53.4% нь, ГССҮТ-ийн үйлчлүүлэгчдийн 57.1% нь сэтгэл ханамжгүй байна.


Эмнэлгийн хоолны амт, чанарын талаар хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 84.2%-тай, баллаар авч үзвэл 1.32 буюу “сайн” үнэлгээтэй байна.

ЗУРАГ 53. ЭМНЭЛГИЙН ХООЛНЫ АМТ ЧАНАРЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН



Эмнэлгийн хоолны амт, чанарын сэтгэл ханамжийн түвшинг байгууллагаар авч үзвэл УИТЭ, ХСҮТ, ХТС өндөр хувьтай байна. ГССҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 71.7% тай байгаа нь хамгийн бага үнэлгээ болж байна.


ЗУРАГ 54. ЭМНЭЛГИЙН ХООЛНЫ АМТ ЧАНАРЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ



Эмнэлгийн хоолны амт, чанарын сэтгэл ханамжийг хэвтэн эмчлүүлэгчдийн 71.8% нь сайн, 24.8% нь дунд, 3.4% нь муу гэж үнэлсэн байна. Байгууллагаар авч үзвэл ХТС, ХСҮТ нь хамгийн өндөр хувьтай байна. ЭХЭМҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн 53.4% нь, ГССҮТ-ийн үйлчлүүлэгчдийн 46.0%, УИТЭ-ийн 39.4% нь, ХӨСҮТ-ийн 33.8%, нь сэтгэл ханамжгүй байна.

Эмчилгээ, үйлчилгээний аюулгүй байдлын талаар анхааруулга, мэдээлэл өгдөг байдалд хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 86.5%, амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 79.0%-тай, баллаар авч үзвэл 1.27-1.42 буюу “сайн” үнэлгээтэй байна.

ЗУРАГ 55. ЭМЧИЛГЭЭ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН




ЭМСЯ-НЫ ХАРЬАА БАЙГУУЛЛАГУУДЫН ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

Эмчилгээ, үйлчилгээний аюулгүй байдлын талаар анхааруулга, мэдээлэл өгдөг байдлын сэтгэл ханамжийн түвшинг байгууллагаар авч үзвэл УИТЭ, СЭМҮТ, ХСҮТ, ХТС, ГҮТ өндөр хувьтай байна.

ГССҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 72.7 байгаа нь хамгийн бага үзүүлэлт болж байна.

ЗУРАГ 56. ЭМЧИЛГЭЭ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ




Эмчилгээ, үйлчилгээний аюулгүй байдлын талаар анхааруулга, мэдээлэл өгдөг байдлыг хэвтэн эмчлүүлэгчдийн 74.6% нь, амбулаторын үйлчлүүлэгчдийн 61.8% нь сайн гэж үнэлсэн бол, 31.8 ± 6.4% нь сэтгэл ханамжгүй байна. Амбулаторын үйлчлүүлэгчдийн 38.2% нь сэтгэл ханамжгүй байна.

Байгууллагаар авч үзвэл ХСҮТ-ийн хэвтэн эмчлүүлэгчид 92.8% нь сайн гэж үнэлсэн нь хамгийн өндөр үзүүлэлт болж байгаа бол, УИИТЭ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн 47.9%, ЭХЭМҮТ-ийн 44.5%, ГССҮТ-ийн 46.6% нь дунд, муу гэсэн үнэлгээ өгчээ.

4.3. Эмнэлгийн эрүүл ахуйн аюулгүй байдал


Эмнэлгийн халдвар хамгааллын дэглэм, эрүүл ахуйн аюулгүй байдлын хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 89.2%, амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 82.0%-тай, баллаар авч үзвэл 1.22-1.36 буюу “сайн” үнэлгээтэй байна.

ЗУРАГ 57. ЭМНЭЛГИЙН ЭРҮҮЛ АХУЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН



Эмнэлгийн халдвар хамгааллын дэглэм, эрүүл ахуйн аюулгүй байдлын сэтгэл ханамжийн түвшинг байгууллагаар авч үзвэл УИИТЭ, СЭМҮТ, ХСҮТ, ХТС, ГҮТ өндөр хувьтай байна. ГССҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 67.8% байгаа нь хамгийн бага үзүүлэлт юм.


ЗУРАГ 58. ЭМНЭЛГИЙН ЭРҮҮЛ АХУЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ



Эмнэлгийн халдвар хамгааллын дэглэм, эрүүл ахуйн аюулгүй байдлыг хэвтэн эмчлүүлэгчдийн 79.7% нь, амбулаторын үйлчлүүлэгчдийн 67.0% нь сайн гэж үнэлсэн бол, 26.6± 6.3% нь сэтгэл ханамжгүй байна. Амбулаторын үйлчлүүлэгчдийн 33.0% нь сэтгэл ханамжгүй байна. Байгууллагаар авч үзвэл ХСҮТ-ийн хэвтэн эмчлүүлэгчид 95.7% нь сайн гэж үнэлсэн нь хамгийн өндөр үзүүлэлт юм. ЭХЭМҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчийн 45.7%, ГССҮТ-ийн 55.6% нь дунд, муу гэсэн үнэлгээ өгчээ.


Эмнэлгийн угаалга, цэвэрлэгээнд хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 89.5%, амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 83.4%-тай, баллаар авч үзвэл 1.22-1.33 буюу “сайн” үнэлгээтэй байна.

ЗУРАГ 59. ЭМНЭЛГИЙН УГААЛГА, ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН



Эмнэлгийн угаалга, цэвэрлэгээний сэтгэл ханамжийн түвшинг байгууллагаар авч үзвэл УИТЭ, УИИТЭ, СЭМҮТ, ХСҮТ, ХТС, ГҮТ өндөр хувьтай байна. ГССҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 69.4% байгаа нь хамгийн бага үзүүлэлт юм.

ЗУРАГ 60. ЭМНЭЛГИЙН УГААЛГА, ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ



Эмнэлгийн угаалга, цэвэрлэгээг хэвтэн эмчлүүлэгчдийн 80.7% нь, амбулаторын үйлчлүүлэгчдийн 70.3% нь сайн гэж үнэлсэн бол, $24.5 \pm 5.2\%$ нь сэтгэл ханамжгүй байна. Амбулаторын үйлчлүүлэгчдийн 29.7% нь сэтгэл ханамжгүй байна. Байгууллагаар авч үзвэл УИТЭ, СЭМҮТ, ХСҮТ-ийн хэвтэн эмчлүүлэгчид 93.6-аас дээш хувиар сайн гэж үнэлсэн байна. ЭХЭМҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчийн 44.4%, ГССҮТ-ийн 53.3% нь дунд, муу гэсэн үнэлгээ өгчээ.

4.4.Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар хэрэглэгчид юуг, ямар байхыг хүсэв

Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахын эмч, ялангуяа сувилагчийн хүртээмжийг нэмэгдүүлэх, лабораторын шинжилгээний нэр төрлийг олшруулан, хэрэгцээт урвалж бодисоор хангах, аль болох хувийн лаборатори санал болгохгүй байх, эрүүл мэндийн даатгалын ач холбогдолыг нэмэгдүүлэх нь чухал гэж үзэж байна.

Эмнэлгийн орны менежмент, бүртгэлийн систем, цагийн хуваарийг оновчтой болгох замаар ачааллыг бууруулах, цагийн тариаг цагт нь хийхийн тулд эмчилгээний зөв зохицуулалт хийх, хэвтэн эмчлүүлэгчдийг хүнд, хөнгөнөөр ангилан дугаар өгдөг байх, ар гэрийн эргэлтийн хуваарийг зөв гарган, дотоод журмаа мөрдөж ажиллах шаардлагатай гэсэн байна.

Сувилагч нар ямар тариа хийж байгаагаа хэлдэггүй, стандартаа мөрдөж ажилладаггүй, шаардлага тавихаар уцаартай хүлээж авдаг, ёс зүйгүй, ур чадвар муутай гэж цөөнгүй иргэд үзжээ.

Мөн тариа хийхдээ бээлийгээ солихгүй байгаа нь тариа хийх үйлдлийн аюулгүй байдал, халдвар хамгааллыг зөрчиж байгааг эмнэлгийн удирдлага анхааралдаа авах хэрэгтэйг сануулсан байна.

Лабораторын шинжилгээ, дүрс оношилгоо хийлгэхэд ихээхэн эдийн засгийн хүндрэл учирдаг, байнга нэмж шинжилгээний мөнгө төлдөг тул даатгалаас төлдөг мөнгийг дараа сард нь эсвэл хуримтлуулсан байдлаар улирлаар тооцдог бол даатгал бодит утгаар үйлчилнэ гэж үзэж байна.

Өвчтөнг 7 хоног болгоод эмнэлгээс гаргадаг нь эмчилгээний чанар алдагдах, өвчин архагших нэг шалтгаан гэсэн байна.

Мөн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хүрэлцээ, ялангуяа гемодиализын аппаратыг нэмэгдүүлэх, Засгийн газраас санхүүжилтийг хангалттай олгох, эмч, мэргэжилтний ажлын ачаалалд тохирсон цалин өгдөг байх, эрүүл мэндийн спортын сайдыг томилох, эрүүл мэндийн салбарыг улс төрөөс хол байлгах хэрэгтэйг сануулсан байна.

Асуудал 7. Хэвтэн эмчлүүлэхэд зайлшгүй шаардлагатай эм, тариа дутмагаас гаднаас эм, тариа авчирч эмчлүүлж байна. Энэ нь санхүүжилттэй холбоотойг ойлгож байна. Гэхдээ эмгүй эмнэлгийг эмнэлэг гэх үү...

Асуудал 8. Цөөхөн хоног төгс бус эмчилдэг. Эмчилгээ дутуу учир ойрхон хэвтэж, хүндэрч буй мэт санагдах юм. Эрүүл мэндийн мэдээлэл авч баймаар байна. Сургалт сурталчилгааг зохион байгуулж баймаар байна. Нас өндөр гарсан хүмүүст уламжлалт эмчилгээ их хэрэгтэй байгааг биеэрээ мэдэрч байна. Уламжлалт эмчилгээний орны тоог нэмэн, олон аргыг нэвтрүүлэхийг хүсч байна.

Асуудал 9. Эмч нар буруу онош тавьсанаас би их хохирсон. 2001 онд зүрхний буруу онош тавьсанаас хүүхдээ авхуулсан. Дараа нь эмч нарын маргааныг таслахын тулд зүрхний зонд хийлгэхэд цоорхой биш байсан. Эцэст нь би 3-4 сартай ураг таслуулж, хохирсон. Гомдолтой явдаг.

БҮЛГИЙН ДҮГНЭЛТ


Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдал, дэмжих үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эмнэлгийн эрүүл ахуйн аюулгүй байдал гэсэн 3 дэд бүлгийн хүрээнд 13 хэмжигдэхүүнээр амбулатор, хэвтэн эмчлүүлэгчээр харьцуулан гаргалаа.

ЭМСЯ-НЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

Бүх үзүүлэлтээр эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамж, амбулаторын үйлчлүүлэгчдээс тогтмол өндөр байна.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдалд хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 88.4%, амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 81.4%-тай, баллаар авч үзвэл 1.23-1.37 буюу сэтгэл ханамж “сайн” байна.

ЗУРАГ 61. ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН



Байгууллагаар, ерөнхий дүнгээр авч үзвэл, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдалд УИТЭ, УИИТЭ, СЭМҮТ, ХСҮТ, ХТС-ийн хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 90.0-ээс дээш хувьтай, сэтгэл ханамж өндөр байна.

ГССҮТ нь амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшингээр 70.8%тай байгаа нь хамгийн бага үзүүлэлт юм. Хэрэглэгчдийн үнэлгээний үзүүлэлт буюу сайн, дунд, муу гэсэн үнэлгээнээс харахад ХСҮТ, СЭМҮТ, ХТС, УИИТЭ-ийн сайн гэсэн үнэлгээ давамгайлж байхад, ЭХЭМҮТ, ГССҮТ-ийн хангалтгүй гэсэн үнэлгээ цөөнгүй үзүүлэлтэд харагдаж байна.

Дийлэнхдээ амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн үзүүлэлт бага байгаа ба дунджаар 30.0 орчим хувийг эзэлж байна.

Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар хэрэглэгчид эмч, ялангуяа сувилагчийн хүртээмжийг нэмэгдүүлэн шинжилгээний нэр төрлийг олшруулах, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх, стандартаа мөрдөж ажиллах, эрүүл мэндийн даатгалын ач холбогдолыг нэмэгдүүлэхийг түлхүү хүсэж байна.


БҮЛЭГ 5. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

5.1. Удирдлага зохион байгуулалт

Энэхүү бүлэгт эмнэлгийн удирдлага, зохион байгуулалтын талаарх хэрэглэгчийн сэтгэл ханамжийг тасаг нэгжийн зохион байгуулалт, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэдэг, мэдээлэл, сурталчилгааны зохион байгуулалт гэсэн 4 хэмжигдэхүүнээр тодорхойлсон.


Үзлэг, оношилгооны кабинет, тасаг нэгжийн байршлын зохион байгуулалтад хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 90.2%-тай, амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 84.5%-тай, баллаар авч үзвэл 1.20-1.31 буюу “сайн” үнэлгээтэй байна.

ЗУРАГ 62. КАБИНЕТ, ТАСАГ НЭГЖИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН



Сэтгэл ханамжийн түвшинг байгууллагаар авч үзвэл хэвтэн эмчлүүлэгчийн сэтгэл ханамж УИИТЭ, ГССҮТ, ХӨСҮТ-ээс бусад байгууллага 90.0-ээс дээш хувьтай байна. ГССҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 60.1%-тай “дунд” үнэлгээтэй байна.

ЗУРАГ 63. КАБИНЕТ, ТАСАГ НЭГЖИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ




Үзлэг, оношилгооны кабинет, тасаг нэгжийн байршлын зохион байгуулалтад хэвтэн эмчлүүлэгчдийн 81.7% нь, амбулаторын үйлчлүүлэгчдийн 71.7% нь сайн гэж үнэлсэн бол 23.3±5% нь сэтгэл ханамжгүй байна.

Байгууллагаар авч үзвэл ХСҮТ, УИТЭ-ийн сэтгэл ханамж хамгийн өндөртэй, ГССҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн 59.6% хувь нь сэтгэл ханамжгүй байна.


Байгууллагын удирдлагаас иргэдийн оролцоог дээдлэн, уулзаж, санал бодлыг сонсон, шийдэж өгдөг байдалд хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 80.9%-тай, амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 72.4%-тай, баллаар авч үзвэл 1.38-1.55 буюу “сайн” үнэлгээтэй байна. Гэхдээ амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин дунд гэсэн үнэлгээнд нилээн ойрхон очсон байна.

ЗУРАГ 64. УДИРДЛАГААС ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАН, САНАЛЫГ СОНСДОГ БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН



Байгууллагаар авч үзвэл ХСҮТ 95.6%, ГҮТ 94.1%-тай, бусад байгууллага 90.0-ээс доош хувьтай байна. Амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин ихэнхдээ 70.0 гаруй хувьтай, ЭХЭМҮТ, ГССҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин “дунд” үнэлгээтэй байна.


ЗУРАГ 65. УДИРДЛАГААС ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАН, САНАЛЫГ СОНСДОГ БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ



Байгууллагын удирдлагаас иргэдийн оролцоог дээдлэн, уулзаж, санал бодлыг сонсон, шийдэж өгдөг байдалд хэвтэн эмчлүүлэгчдийн 67.7% нь, амбулаторын үйлчлүүлэгчдийн 52.7% нь сайн гэсэн бол 39.8± 7.5 % нь сэтгэл ханамжгүй байна. Байгууллагаар авч үзвэл хэвтэн эмчлүүлэгчдээс амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж бага, тухайлбал: УИТЭ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн 58.3%, ЭХЭМҮТ-ийн 64.7%, ГССҮТ-ийн 72.0% нь сэтгэл ханамжгүй байна.


Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах, хариу өгөх, авсан арга хэмжээг нээлттэй хүргэдэг байдалд хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 82.0%-тай, амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 73.5%-тай, байгууллагын удирдлагад өгсөн үнэлгээтэй ойролцоо түвшинд байна.

ЗУРАГ 66. ИРГЭДИЙН САНАЛ, ХҮСЭЛТИЙГ ШИЙДВЭРЛЭН ЭРГЭН МЭДЭЭЛДЭГ БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН



Сэтгэл ханамжийн түвшинг байгууллагаар авч үзвэл ХСҮТ, ГҮТ хамгийн өндөр хувьтай байна. ГССҮТ, ЭХЭМҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин “дунд” үнэлгээтэй байна.


ЗУРАГ 67. ИРГЭДИЙН САНАЛ, ХҮСЭЛТИЙГ ШИЙДВЭРЛЭН ЭРГЭН МЭДЭЭЛДЭГ БАЙДЛЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ



Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах, хариу өгөх, авсан арга хэмжээг нээлттэй хүргэдэг байдалд хэвтэн эмчлүүлэгчдийн 67.6% нь, амбулаторын үйлчлүүлэгчдийн 64.8% нь сайн гэж үнэлсэн бол 33.8± 1.4 % нь сэтгэл ханамжгүй, дунд, муу гэсэн үнэлгээ өгчээ. Байгууллагаар авч үзвэл ХСҮТ-ийн хэвтэн эмчлүүлэгчид сэтгэл ханамж хамгийн өндөр, ГССҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж хамгийн бага байна.


Эрүүл мэндийн сургалт, сурталчилгааг зохион байгуулдаг байдалд хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 82.0%-тай, амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 76.6%-тай, баллаар авч үзвэл 1.36-1.47 буюу “сайн” үнэлгээтэй байна.

ЗУРАГ 68. ЭРҮҮЛ МЭНДИЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН



Байгууллагаар авч үзвэл УИИТЭ, СЭМҮТ, ХСҮТ-ийн хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 90.0-ээс дээш хувьтай байна. ГССҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин 57.3%тай, “дунд” үнэлгээтэй байна.

ЗУРАГ 69. ЭРҮҮЛ МЭНДИЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ



Эрүүл мэндийн сургалт, сурталчилгааг зохион байгуулдаг байдалд хэвтэн эмчлүүлэгчдийн 68.5% нь, амбулаторын үйлчлүүлэгчдийн 59.2% нь сайн гэж үнэлсэн ба сэтгэл ханамжгүй байдал 36.1 ± 4.6%-тай байна. Амбулаторын үйлчлүүлэгчдийн 40.8% нь сэтгэл ханамжгүй байна.

Байгууллагаар авч үзвэл ХСҮТ-ийн хэвтэн эмчлүүлэгчид, ГҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж хамгийн өндөр, ХӨСҮТ-ийн хэвтэн эмчлүүлэгч, ГССҮТ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж хамгийн бага байна.

5.2. Удирдлага, зохион байгуулалтын талаар хэрэглэгчид юуг, ямар байхыг хүсэв

Амбулаторын тусламж, үйлчилгээ, оношилгоо, үзлэгийн цахим бүртгэл, мэдээллийн зохион байгуулалт, үйл ажиллагаа, цахим бүртгэлийн ажилчдын харилцаа, хандлагад хэрэглэгчид хамгийн их бухимдалтай байна.

Дийлэнх хэрэглэгчид нэг эмчид үзүүлээд дараагийн эмчид үзүүлэх бүртээ, шинжилгээ хийлгэх тоолондоо дахин дахин цахимаас дугаар авах, очерлох шаардлага гарч хүлээгдэл, хүндрэл үүсгэдэг, энэ нь оношилгоо, шинжилгээ, үзлэгийн зохион байгуулалттай шууд холбоотой хэмээн шүүмжилж байна.

Ялангуяа “нэг хүний төлөө нэг хэсэг хүн” ирэхээс өөр аргагүй болгодог эмнэлгийн үйлчилгээ, хүлээлгээс болоод хөдөө орон нутгаас ирсэн иргэд, ахмад настанд эрүүл мэндийн болоод эдийн засгийн ихээхэн хүндрэл гарч байгааг учирлаж байна.

Яаралтай, хүнд, гарцаагүй эмнэлэгт хэвтэх шаардлагатай тохиолдолд амь насны эрсдэл тулгарахыг ч үгүйсгэхгүй байна.

Тухайлбал: Үзлэг, оношилгооны дараалал авахад 7-10 хоног ордог, үзүүлсэний дараа хэвтэхэд 7-10 хоног болдог, хэвтэх үедээ хэвтэх бичиг авах, истори нээлгэхэд 40-50 хүний дараалал үүсэн, дахин очерлох шаардлага гардаг, энэ бүхнийг хүнд өвчтэй хүн даван туулах тэвчээр барагдаж, олон дахин эмнэлгээр явахаас халширч, улмаар өвчин нь хүндрэн, гэртээ нас эцэслэхэд хүрч байна, энэ нь эмнэлгийн зохион байгуулалттай холбоотой гэсэн байна.

Асуудал 10. *Эртээр нэг өвчтөнг аль хэдийн энэ эмнэлэгт шинжилгээ өгөөд зөвхөн эмчид үзүүлж хагалгаанд орох бичгээ авах шаардлагатай байхад нь “13А авч ир” гэсэн. Өвчтөй хүн “эмч байхгүй байна цагаа л бичүүлээд ир” гэсэн гэж хичнээн хэлсэн ч цахимыхан цагийг нь өгөхгүй, ажлын цаг нь дуусаад, тэр хүн яаж ч чадалгүй гарсан. Хүнд сурталаа болимоор байна. Цахимийн хүмүүс дэндүү их зантай, өвчтэй хүнтэй харилцаж байгаагаа мэдэх хэрэгтэй. Бас урдуур нь таньдаг хүмүүс, захиасны хүмүүстээ очер өгдөг нь үнэн шүү дээ.*


Асуудал 11. *Шинжилгээний очер дийлдэхгүй байна. Эмчид үзүүлэх, шинжилгээ хийлгэх бүрдээ ахин дахин дугаар авч цахимын хүлээлгэнд удаан суухад хүндрэлтэй. Тийм эмчид үзүүлбэ гээд хүсэлт гаргах боломжгүй, заавал нэг эмчээс бичиг авч ирдэг нь хэцүү. Жнь : Бамбайн эмчид үзүүлчихээд, өөрийн хүсэлтээр нүдний дугаар давхар авч болдоггүй. Мөн авсан цагаараа үйлчлүүлж чадахгүй байна.*

Асуудал 12. *Цахим бүртгэлийнхэн нь хүмүүстэйгээ хүрч ажиллаж сайн тайлбарлахгүй байна. Цахимаар цаг бүртгэж өгдөг хүмүүс нь аашаа жаахан зассан дээр юм шиг санагдлаа. Цахим бүртгэлийн ажилтанг нэмэх, ур чадварыг сайжруулан 10 хурууны бичээчээр сургах шаардлагатай байна.*

БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Удирдлага зохион байгуулалтыг ханамжийг тасаг нэгжийн зохион байгуулалт, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авдаг, шийдвэрлэдэг, мэдээлэл, сурталчилгааны зохион байгуулалт гэсэн 4 хэмжигдэхүүнээр амбулатор, хэвтэн эмчлүүлэгчээр харьцуулан судлалаа. Бүх үзүүлэлтээр амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээ хангалтгүй байна.

ЗУРАГ 70. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТАД СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН



Байгууллагаар, ерөнхий дүнгээр авч үзвэл УИТЭ, СЭМҮТ, ХСҮТ-ийн хэвтэн эмчлүүлэгчид, ГҮТ-ийн үйлчлүүлэгчдийн үнэлгээ 90.0-ээс дээш хувьтай байна. ГССҮТ нь амбулаторын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшингээр 58.0%тай байгаа нь дунд үнэлгээ юм.

Хэмжигдэхүүнээр, сэтгэл ханамжгүй байдал илүү харагдаж байгаа амбулаторын үйлчлүүлэгчдийг авч үзвэл, кабинет, тасаг нэгжийн зохион байгуулалтад 28.3% нь, байгууллагын удирдлагаас иргэдийн оролцоог дээдлэх, уулзаж, санал бодлыг сонсон шийдвэрлэдэг байдалд 47.3%, санал хүсэлтийг хүлээн авах, эргэн мэдээлэлтэд 45.2% нь, эрүүл мэндийн мэдээлэл, сургалт сурталчилгааны зохион байгуулалтад 40.8% нь дунд, муу гэсэн үнэлгээ өгчээ.

Байгууллагаар авч үзвэл энэ бүлэгт ХСҮТ нь хамгийн өндөр үнэлгээтэй, ГССҮТ нь хамгийн бага үнэлгээтэй байна. *Нээлттэй асуулгаар удирдлага, зохион байгуулалтын талаар хэрэглэгчид амбулаторын тусламж, үйлчилгээ, оношилгоо, үзлэгийн цахим бүртгэл, мэдээллийн зохион байгуулалт, үйл ажиллагаа, цахим бүртгэлийн ажилчдын харилцаа, хандлагыг өөрчлөх, хүлээгдэлийг бууруулах, үйлчилгээний тав тухтай байдлыг хангахыг хамгийн их хүсэж байна.*

ХҮСНЭГТ 9. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ТҮВШИН

Эмнэлгийн нэр	4.1. Үзлэг, оношилгооны кабинет, тасаг нэгжийн байршил, тэмдэглэгээ, зохион байгуулалт		4.2. Байгууллагын удирдлагаас иргэдийн оролцоог дээдэлдэг, уулзаж, санал бодлыг сонсдог, шийдэж өгдөг байдал		4.3. Иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авах, хариу өгөх, авсан арга хэмжээг нээлттэй хүргэдэг байдал		4.4. Эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааны зохион байгуулалт		Бүлгийн дундаж	
	Балл	%	Балл	%	Балл	%	Балл	%	Балл	%
УИТЭ	1.10	95.0	1.25	87.4	1.25	87.4	1.25	87.6	1.21	89.4
АУ	1.28	86.0	1.51	74.6	1.52	74.1	1.49	75.4	1.45	77.5
УИПЭ	1.04	98.1	1.24	87.8	1.41	89.3	1.20	90.1	1.17	91.3
АУ	1.15	92.4	1.46	77.1	1.41	79.3	1.27	86.4	1.32	83.8
УИПЭ	1.25	87.7	1.52	73.9	1.49	75.4	1.44	77.8	1.43	78.7
АУ	1.39	80.4	1.66	67.1	1.64	68.2	1.56	71.9	1.56	71.9
ЭХЭМҮТ	1.18	90.9	1.47	76.4	1.42	78.9	1.39	80.7	1.37	81.7
АУ	1.42	79.1	1.76	61.9	1.69	65.7	1.62	69.0	1.62	68.9
ХӨСҮТ	1.37	81.6	1.46	76.9	1.51	74.5	1.52	73.8	1.47	76.7
АУ	1.19	90.3	1.36	82.0	1.29	85.4	1.31	84.6	1.29	85.6
СЭМҮТ	1.08	96.2	1.21	89.4	1.25	87.5	1.17	91.3	1.18	91.1
АУ	1.06	97.2	1.33	83.3	1.28	86.1	1.28	86.1	1.24	88.2
ГССҮТ	1.37	81.3	1.53	73.6	1.49	75.7	1.51	74.3	1.47	76.3
АУ	1.80	60.1	1.88	56.1	1.83	58.4	1.85	57.3	1.84	58.0
ХСҮТ	1.06	97.1	1.09	95.6	1.08	96.0	1.09	95.4	1.08	96.0
АУ	1.26	86.9	1.48	76.0	1.49	75.6	1.38	80.8	1.40	79.9
АӨСҮТ	1.12	94.1	1.44	78.1	1.31	84.5	1.33	83.3	1.30	85.2
АУ	1.20	90.2	1.41	79.4	1.45	77.5	1.37	81.7	1.36	82.2
ХТС	1.14	92.9	1.30	85.1	1.25	87.5	1.49	75.7	1.29	85.6
ГҮТ	1.06	97.2	1.12	94.1	1.08	96.1	1.08	96.2	1.08	95.9
АУ	1.20	90.2	1.38	80.9	1.36	82.0	1.36	82.0	1.32	83.8
Дундаж	1.31	84.5	1.55	72.4	1.53	73.5	1.47	76.6	1.46	76.8

ХҮСНЭГТ 10. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ

Эмнэлгийн нэр	4.1. Үзлэг, оношилгооны кабинет, тасаг нэгжийн байршил, тэмдэглэгээ, зохион байгуулалт		4.2. Байгууллагын удирдлагаас иргэдийн оролцоог дээдэлдэг, уулзаж, санал бодлыг сонсдог, шийдэж өгдөг байдал		4.3. Иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авах, хариу өгөх, авсан арга хэмжээг нээлттэй хүргэдэг байдал		4.4. Эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааны зохион байгуулалт	
	Сайн	Муу	Сайн	Муу	Сайн	Муу	Сайн	Муу
УИТЭ	90.1	9.9	77.0	20.7	2.3	21.6	78.4	18.5
АУ	73.4	25.3	59.9	29.3	10.8	34.3	56.9	37.0
УИПЭ	96.2	3.8	76.3	22.9	0.8	21.4	82.4	15.3
АУ	84.8	15.2	56.4	41.4	2.2	35.9	74.5	23.9
УИПЭ	75.8	23.7	52.2	43.5	4.3	38.6	61.4	32.9
АУ	62.8	35.1	41.7	50.8	7.4	48.8	49.2	45.5
ЭХЭМҮТ	83.7	14.2	59.3	34.1	6.5	30.7	66.7	28.0
АУ	61.2	35.8	35.3	53.0	11.6	43.5	47.4	43.1
ХӨСҮТ	82.1	16.4	70.3	35.2	5.5	40.1	55.6	36.3
АУ	92.3	7.7	82.7	13.5	3.8	25.0	73.8	21.5
СЭМҮТ	94.4	5.6	72.2	22.2	5.6	16.7	82.7	17.3
АУ	65.2	32.1	52.8	41.5	5.7	37.3	51.4	45.7
ГССҮТ	40.4	39.3	28.0	56.1	15.9	44.6	35.4	43.9
АУ	94.2	5.8	91.2	8.8	0.0	6.6	91.5	7.7
ХСҮТ	76.1	21.6	60.5	31.0	8.5	33.1	67.7	26.2
АУ	88.2	11.8	60.7	34.8	4.5	23.9	71.1	24.6
АӨСҮТ	81.0	18.4	62.5	33.8	3.8	36.3	64.6	34.2
АУ	85.7	14.3	73.0	24.3	2.7	20.0	62.2	27.0
ХТС	94.3	5.7	88.2	11.8	0.0	7.8	92.3	7.7
АУ	81.7	16.9	65.7	30.4	4.0	28.7	68.5	27.1
Дундаж	71.7	25.7	52.7	39.4	8.0	37.3	59.2	34.9


БҮЛЭГ 6. ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЭГШ БАЙДАЛ, АШИГ СОНИРХОЛ

Тусламж, үйлчилгээний тэгш байдлыг тусламж, үйлчилгээний хүлээгдэл, эмчээ сонгон үзүүлэх боломж, эмчилгээний хүртээмж, эмч, эмнэлгийн ажилтны тэгш, ялгаваргүй ханддаг эсэх, эрүүл мэндийн даатгалгүй тохиолдолд тусламж, үйлчилгээг чирэгдэлгүй авдаг эсэхэд хариулт авахыг зорьлоо. Ашиг сонирхолыг эмч, эмнэлгийн мэргэжилтэн хувийн эмнэлэг, эмийн сан, сүлжээ санал болгодог болон үйлчилгээг шуурхай болгохын тулд шан харамж, албан бус төлбөр өгөх шаардлага тулгардаг талаар тандлаа. Мөн энэхүү бүлэгт “Та биднээс юуг, ямар байхыг хүсч байна вэ” гэсэн асуултаар нээлттэй хариулт аван, дүн шинжилгээ хийснийг оруулав.

6.1. Тусламж, үйлчилгээний тэгш байдал

Эрүүл мэндийн даатгалгүй тохиолдолд тусламж, үйлчилгээг чирэгдэлгүй авах боломжтой гэж хэвтэн эмчлүүлэгчдийн 32.3% нь үзсэн бол 27.5% нь боломжгүй, 40.2% нь мэдэхгүй гэжээ. Амбулаторын үйлчлүүлэгчдийн хувьд 21.1% нь боломжтой, 40.4% нь боломжгүй, 32.5% энэ талаар мэдэхгүй байгаагаа илэрхийлсэн байна.


ЗУРАГ 71. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛГҮЙГЭЭР ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ БОЛОМЖ



Эрүүл мэндийн даатгалгүй тохиолдолд тусламж, үйлчилгээг чирэгдэлгүй авах боломжийг байгууллагаар авч үзвэл ХӨСҮТ, СЭМҮТ, ГҮТ-ийн үйлчлүүлэгчдийн талаас дээш хувь нь боломжтой гэж үзжээ. УИТЭ-ийн амбулаторын үйлчлүүлэгчдийн 61.3%, УИИТЭ-ийн үйлчлүүлэгчдийн 43.0%, ЭХЭМҮТ-ийн үйлчлүүлэгчдийн 42.2% нь ХСҮТ-ийн үйлчлүүлэгчдийн 38.9% нь боломжгүй гэдэгт итгэлтэй байна. Харин эрүүл мэндийн даатгалгүй боловч тусламж, үйлчилгээг чирэгдэл багатай авах боломжийн талаар хэрэглэгчдийн 33.3-48.8% нь мэдэхгүй байна.

Эмчээ сонгон үйлчлүүлэх боломжтой гэж хэвтэн эмчлүүлэгчдийн 35.3% нь үзсэн бол 22.6% нь боломжгүй, 42.2% нь мэдэхгүй гэжээ. Амбулаторын үйлчлүүлэгчдийн хувьд 39.7% нь боломжтой, 28.4% нь боломжгүй, 31.8% мэдэхгүй гэсэн байна.


ЗУРАГ 72. ЭМЧЭЭ СОНГОН ҮЗҮҮЛЭХ БОЛОМЖ



Эмчээ сонгон үзүүлэх боломжийг байгууллагаар авч үзвэл, ХСҮТ, СЭМҮТ, ГҮТ-ийн үйлчлүүлэгчдийн талаас дээш хувь нь боломжтой гэсэн байна. Аль ч эмнэлгийн үйлчлүүлэгчдийн нилээдгүй хувь буюу 32.2-57.9% нь эмчээ сонгон үзүүлэх боломжийг мэдэхгүй гэсэн байна.

Эмнэлэгт таних хүнгүй бол тусламж, үйлчилгээ авахад хүндрэлтэй гэж хэвтэн эмчлүүлэгчдийн 25.3%, амбулаторын үйлчлүүлэгчдийн 33.8% нь үзсэн байна.


ЗУРАГ 73. ЭМНЭЛЭГТ ТАНИХ ХҮНГҮЙ БОЛ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ АВАХАД ХҮНДРЭЛТЭЙ



Байгууллагаар авч үзвэл таних хүнгүй бол их хүндрэл тулгардаг байгууллагаар ГССҮТ (56.3%), УИИТЭ (48.8%), ЭХЭМҮТ (43.5%)-ийг, хамгийн бага хүндрэл гардаг байгууллагаар ГҮТ (88.9%), УИИТЭ (62.6%), СЭМҮТ (61.1%), ХСҮТ (69.1%), ХТС (61.4%) -ийг тус тус нэрлэсэн байна. Хэрэглэгчдийн 21.2-46.0% нь энэ талаар мэдэхгүй гэсэн байна.

Эмнэлэгт хэвтэхэд гаднаас эм тариа авхуулдаг гэж хэвтэн эмчлүүлэгчдийн 32.1% хэлсэн бол 47.4% нь үгүй, 20.5% нь мэдэхгүй гэсэн байна.

ЗУРАГ 74. ЭМНЭЛЭГТ ХЭВТЭХЭД ГАДНААС ЭМ ТАРИА АВХУУЛДАГ




Эмнэлэгт хэвтэхэд гаднаас эм тариа авхуулдаг байгууллагаар ГССҮТ нь 59.6%-иар, УИИТЭ нь 49.8%-иар, УИТЭ нь 46.4%-иар эхний 3 байранд орсон байна.

Харин ЭХЭМҮТ нь 73.0%-иар, ХТС нь 69.8%-иар, АӨСҮТ нь 67.2%-иар гаднаас авхуулдаггүй байгууллагаар эхний 3 байранд орж байна. Эмнэлэгт хэвтэхэд гаднаас эм тариа авхуулдаг талаар хэвтэн эмчлүүлэгчдийн 10.1-24.2% нь мэдэхгүй гэсэн байна.

6.2. Ашиг сонирхол

Тусламж, үйлчилгээ авах, хүлээгдлийг багасгах, үйлчилгээг шуурхай болгохын тулд шан харамж, албан бус төлбөр өгөх шаардлага гардаг гэж хэвтэн эмчлүүлэгчдийн 18.0% нь үзсэн бол амбулаторын үйлчлүүлэгчдийн 20.2% нь зөвшөөрсөн байна.

ЗУРАГ 75. ШАН ХАРАМЖ, АЛБАН БУС ТӨЛБӨР




Хэрэглэгчдийн 50.0 орчим хувь нь тусламж, үйлчилгээ авахдаа шан харамж, албан бус төлбөр өгөх шаардлага гардаггүй гэжээ. Байгууллагаар авч үзвэл шан харамж, албан бус төлбөр өгөх шаардлага гардаг байгууллагаар ГССҮТ нь 38.6%-иар, ЭХЭМҮТ 28.4%-иар, СЭМҮТ 27.8%-иар эхний 3 байранд орсон байна.

Харин ГҮТ нь 92.6%-иар, ХСҮТ нь 80.3%-иар, ХТС нь 69.8%-иар, УИИТЭ нь 64.1%-иар шан харамж, албан бус төлбөр өгөх шаардлага гардаггүй байгууллагаар эхний 3 байранд орж байна.

Эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь хувийн эмнэлэг, эм, эмийн сан, сүлжээ санал болгодог, хувиасаа эм зардаг гэж хэвтэн эмчлүүлэгчдийн 11.4% нь, амбулаторын үйлчлүүлэгчдийн 16.4% нь үзсэн байна.

ЗУРАГ 76. ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ХУВИЙН АШИГ СОНИРХОЛ



Байгууллагаар авч үзвэл эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь хувийн эмнэлэг, эм, эмийн сан, сүлжээ санал болгодог, хувиасаа эм зардаг байгууллагаар СЭМҮТ 27.8%-иар, ГССҮТ нь 26.4%-иар, ЭХЭМҮТ 22.0%-иар эхний 3 байранд орсон байна. Харин ГҮТ нь 92.3%-иар, ХСҮТ нь 74.8%-иар, АӨСҮТ нь 68.9%-иар шан харамж, албан эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь хувийн эмнэлэг, эм, эмийн сан, сүлжээ санал болгодог, хувиасаа эм зардаггүй байгууллагаар эхний 3 байранд нэрлэгдсэн байна. Энэ талаар хэрэглэгчдийн 28.7-41.8% нь мэдэхгүй байгаагаар илэрхийлжээ.

6.3. Тусламж, үйлчилгээний тэгш байдал, ашиг сонирхол талаар хэрэглэгчид юуг, ямар байхыг хүсэв.

Хэвтэн эмчлүүлэгчдээс гарч буй, олон давтагдаж буй хүсэлт нь гаднаас эм, тариа авхуулахгүй байхыг хүсч, эмчилгээний бараг 50 хувь нь өвчтөнөөс гардаг, ялангуяа дуслын систем, өндөр өртөгтэй эм тариа, уураг, инсулин, актовегин, рингер, өвчин намдаах лаа, асаргааны хэрэгслүүдийг тогтмол гаднаас авдаг гэж нэр дурдан тэмдэглэж, нилээдгүй бухимдсан байдал харагдаж байна.

Гаднаас авчруулсан эм тарианы мөнгийг эмнэлгээс буцаан олгох ёстой шийдвэр үйлчлэхгүй байгааг хэлж байна.

Мөн эмнэлгийн ажилтан очер дугаар авсан эсэх нь мэдэгдэхгүй таньдаг хүмүүсээ дагуулан үзүүлдэг, эмч нар хувийн эмнэлэг, хувийн оношилгоог санал болгодог, эм тариа хувиасаа зардаг талаар өгүүлж байна.

Эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүд үйлчлүүлэгчдэд ялгавартай ханддаг, ялгавартай үйлчилгээ үзүүлдэг, танил талдаа илүү анхаарал тавьдаг, шудрага шуурхай үйлчилгээ дутагдаж байгааг олон хүн анхааруулсан байна.

Тусламж, үйлчилгээний хүлээгдэл их байх тутам, эмнэлэгт таних хүнгүй бол тусламж, үйлчилгээ авахад улам хүндрэлтэй, улмаар албан бус төлбөр өгөх шалтгаан болдог талаар дурдаж, тэгш байдлыг бий болгох, ашиг сонирхолоор үйлчлэхээ болих хэрэгтэй гэжээ.

Асуудал 13. Танил талаараа биш дугаараараа бүрэн үйлчилгээ авахыг хүсэж байна. Эмнэлгийн ажилтнууд цахим бүртгэлд өөрсдийн хүмүүсийг өмнүүр оруулдагаа зогсоогоорой. Шудрага шуурхай үйлчлэх танил тал харахгүй баймаар байна. Мөн сахарын өвчтөнд өөрсдийн эм тариаг шахдагийг болих хэрэгтэй.

Асуудал 14. Эм тариа хангалтгүй, шаардлагатай үнэтэй эм тариа дуслыг зөвхөн гаднаас авчран, үндсэндээ өөрөө өөртөө л үйлчилж байна. Үйлчлүүлэгч хүн өөрийн хүссэн эмнэлэгт саадгүй үйлчлүүлэхийг хүсдэгч боломжгүй байна. Ажлын цагаар эмч сувилагч асрагч бүгд гар утсаар ярьдагаа багасгамаар байна. Эмч нар өвчтөнөө сайн сонсдог баймаар байна. Юунд ч яараад байгаа юм бүү мэд хам хум л үзэх юм. Шинжилгээний цагийг уртасгах хүсэлтэй байна.

Асуудал 15. Эмнэлгээс гаргадаг эм тариаг өвчтөн ялгахгүй тэгш, зохион байгуулалтай гаргаж байхыг хүсч байна. Ачаалал ихтэй үзүүлэх гэж бүтэн 14-21 хоногийн өмнө эмчийн цаг авч хүлээдэг. Энэ хугацаанд үзүүлж чадахгүйгээр хорвоог орхин эмнэлгийн тусламж авч чадахгүй хичнээн хүн байгааг мэдэхгүй юм, олон л байгаа байх даа. Ямарч үед эмнэлэг ялгаа алга, улсын нэртэй нь очер дараалал ихтэй, хувийн нэртэй нь үнэ өртөг нь тэнгэрт хадчихсан...

Асуудал 16. Иргэд бидэнд аль болох чирээдэл багатай, тэгш үйлчилвэл сайн байна. Хахууль авдаггүй болбол бүр сайхан байна. Явдал чирээдэл ихтэй эмч ажилтан нь зөвлөгөө мэдээлэл өгөх дургүй. Хувийн эмнэлэг дандаа санал болгодог. Боломжгүй хүмүүс яах вэ? ...

6.4. Эрүүл мэндийн салбар, эрүүл мэндийн байгууллагаас хэрэглэгчид юуг, ямар байхыг хүсэв.

Байгууллагын удирдлагын шийдвэр гаргалт болон асуудлын учир, шалтгааныг зөв олж харахад нотолгоо болгох зорилгоор, бүлэг тус бүрээр авч үзсэн санааг, байгууллага бүрээр, тухайн байгууллагад хандсан гол асуудлуудыг хөндөн, дүн шинжилгээ хийн хүргэж байна. Нийтлэгээр, бүх байгууллагын хэрэглэгчид эмч, мэргэжилтэн маш их ачаалалтай, цалин багатай ажиллаж байгаад нь баярласнаа илэрхийлэн, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчид энэ асуудалд анхаарлаа хандуулахыг хүссэн байна.

УИТЭ-ийн 297 амбулаторын үйлчлүүлэгч, 222 хэвтэн эмчлүүлэгч, нийт 519 хэрэглэгч судалгаанд хамрагдан санал, хүсэлтээ илэрхийлэв. УИТЭ-ийн хувьд тусламж, үйлчилгээний хүлээгдэл, цахим бүртгэл мэдээллийн ажилчдын зан харилцаанд хамгийн их бухимдал үүсч, дугаарыг танил талаар өгдөг гэсэн байна. Эмч, сувилагчийн харилцаа, зөвлөгөө өгөх, чин сэтгэлийн үйлчилгээг хүссэн байна. Мөн гадаадын визинд орох хүмүүсийн болон эрүүл мэндийн хуудсыг бөглөх асуудлыг өөр зохион байгуулалтад оруулах, машины зогсоолыг зөв шийдэх, хоолны амт чанарыг сайжруулах, бие засах өрөөнд аяга, тавгаа угааж байгааг анхаарах, шүүлтүүртэй халуун, хүйтэн усаар хангах, эм

ЭМСЯ-НЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

тариаг гаднаас авчруулахгүй байх, өвчтөнг наад зах нь 10 хоног эмчлэх, гемодиализ эмчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хүсэлтийг олон хүн гаргасан байна.

УИТЭ-ийн 186 амбулаторын үйлчлүүлэгч, 131 хэвтэн эмчлүүлэгч, нийт 317 хэрэглэгч судалгаанд хамрагдан санал, хүсэлтээ илэрхийлэв. УИТЭ-ийн хувьд цахимын ажилтны ёс зүй, харилцаа, бие засах газрын тав тухтай байдал, өрөө тасалгааны халаалтад илүү шүүмжлэлтэй хандаж эмч, сувилагчдыг ачаалал ихтэй ч зөвлөгөө өгөх шаардлагатай гэсэн байна.

Тарианы үйлчилгээг өглөөний 8.30-аас эхлүүлэх, үүдний хэсэгт эмчид үзүүлэх, шинжилгээ өгөх хүмүүст зөвлөгөө өгдөг угтах үйлчилгээг бий болгох, сувилагч мэргэжилтний хувцаслалтын соёлыг анхаарах, гадаад орчны тав тухыг ханган, сандалын тоог нэмэх, гаднаас эм тариа авхуулахгүй байх, 2 давхарын буфетийн үйлчилгээний үнэ өртөг хэт өндөр, хөнгөн хоолны үйлчилгээгүйг анхаарах, уламжлалт эмчилгээний орны тоог нэмэгдүүлэх талаар дийлэнх нь санал, хүсэлт гаргасан байна.

УИИТЭ-ийн 242 амбулаторын үйлчлүүлэгч, 207 хэвтэн эмчлүүлэгч, нийт 449 хэрэглэгч судалгаанд хамрагдан санал, хүсэлтээ илэрхийлэв. УИИТЭ-ийн хувьд тусламж, үйлчилгээний хүлээгдэл, цахим бүртгэлийн ажилтны шуурхай байдал, бие засах өрөөний тав тух, машины зогсоолын хүртээмжгүй байдалд илүү бухимдал үүссэн байна.

Эмч, мэргэжилтний харилцааны соёл, сэхээний тасгуудын хүлээлгийн өрөөний тав тух, сандлын хангамжийг нэмэгдүүлэх, яаралтай тусламжийн хүлээн авах хэсэгт албан бус төлбөр авч байгааг анхаарах, гаднаас эм, тариа авхуулахгүй байх, оронгуут бохирын үнэр үнэртэж, цэвэрлэгээ үйлчилгээ муу байгааг анхаарах хэрэгтэйг хэлсэн байна.

ЭХЭМҮТ-ийн 232 амбулаторын үйлчлүүлэгч, 250 хэвтэн эмчлүүлэгч, нийт 481 хэрэглэгч судалгаанд хамрагдан санал, хүсэлтээ илэрхийлэв. ЭХЭМҮТ-ийн хувьд эмнэлгийн зохион байгуулалт, хөтчийн үйлчилгээ ойлгомжгүй, угтах үйлчилгээ муутай, хүлээлгийн өрөөний тав тух хангагдаагүй, ээжүүд сандал дээр унтдаг, нэг өрөөнд олон хүн хэвтдэг, сахиурын өрөөний бие засах газрын цэвэрлэгээ муу байгаад илүү бухимдаж байна.

Амбулатор, яаралтай тусламжийн эмч, сувилагч болон эх баригч, асрагчийн харилцааг сайжруулах, машины зогсоолыг нэмэгдүүлэх, хүүхдийн биеийн талаар зөвлөгөө, мэдээллээ тодорхой сайн өгдөг байх, шуурхай үйлчлэх, эргэлтийн цагийг оновчтой болгох, цэвэр шүүлтүүртэй усаар хангах, агааржуулалт нэмэх, зарим өрөө мөөгөнцөртэй байгаад арга хэмжээ авахыг хүсэж байна.

ХӨСҮТ-ийн 67 амбулаторын үйлчлүүлэгч, 228 хэвтэн эмчлүүлэгч, нийт 295 хэрэглэгч судалгаанд хамрагдан санал, хүсэлтээ илэрхийлэв. ХӨСҮТ-ийн хувьд лавлагаа мэдээллийн ажилтан, амбулаторын эмч, сувилагч харилцаа, ёс зүй муутай, эмнэлгийн цэвэрлэгээ, цагаан хэрэглэлийн үйлчилгээ тун хангалтгүй, угтах үйлчилгээ, эмнэлгийн зохион байгуулалт ойлгомжгүй, эрэл сурал болж байж тасаг нэгжийг олдог, сувилагч тариа хийхдээ ямар тариа хийх гэж байгаагаа хэлдэггүй, хүнд ялгавартай ханддаг, ашиг сонирхолын зөрчилтэй байдалд илүү бухимдал үүссэн байна. Хэд хэдэн тохиодолд тасаг, хүний нэр дурдан шүүмжилсэн байна. Өрөө тасалгааны цэвэрлэгээ сайн хийх, цагаан хэрэглэлийн угаалга, ариутгалыг сайжруулах, халаалтыг нэмэгдүүлэх, хүнд сурталгүй шуурхай үйлчлэх, тасаг, нэгжийн зохион байгуулалтын тэмдэглэгээг ойлгомжтой хийх, хоолны амт чанарыг сайжруулах, хэрэглэгч эд юмсаа хулгайд алдахаас сэргийлэх, эргэлтийн өрөө, хүүхдийн өрөөг тохижуулахыг хүсэж байна.

СЭМҮТ-ийн 18 амбулаторын үйлчлүүлэгч, 52 хэвтэн эмчлүүлэгч, нийт 70 хэрэглэгч судалгаанд хамрагдан санал, хүсэлтээ илэрхийлэв. СЭМҮТ-ийн хувьд үйлчлүүлэгч бүртэй тулж ажиллах, өвчтөнийг халуун усанд оруулах, бие засах өрөөний тав тухыг хангах асуудалд бухимдал үүсэж байна. Хүлээгдлийг бууруулах, дүүргийн харьяа тасгуудын бие засах өрөөний цэвэрлэгээг сайжруулах, капитал засвар хийх, орыг иж бүрэн солих, камержуулалтын хүртээмжийг нэмэгдүүлэхийг санал болгож байна.

ГССҮТ-ийн 93 амбулаторын үйлчлүүлэгч, 203 хэвтэн эмчлүүлэгч, нийт 296 хэрэглэгч судалгаанд хамрагдан санал, хүсэлтээ илэрхийлэв. ГССҮТ-ийн хувьд цахилгаан шат хүрэлцээгүй, хүнд сурталтай, шуурхай бус, харилцааны соёлгүй, гудамжны орон гэрэгүй хүмүүсийн хоноглодог газар болсон, бие засах газар тав тухгүй, бохир, хагалгааны дараах үйлчилгээ хангалтгүй, гаднаас эм тариа авхуулдаг, тэгш биш байдал үүссэнээс албан бус төлбөр өгдөг, гадуур хувцас, гуталтай хүмүүст хяналт тавихгүй байгаа талаар нилээдгүй бухимдал үүссэн байна.

ЭМСЯ-НЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

Эмнэлгийн барилга, тасаг нэгжийн тав тух, тоног төхөөрөмж, эмч, ажилтны ур чадварыг сайжруулах, бие засах газрын тоо, үйлчилгээний соёлыг сайжруулах, гаднаас эм тариа авхуулахгүй байх, эмч, сувилагчийн ачааллыг зохицуулах, хэвтрийн өвчтэй хүний тав тухыг хангах, агааржуулалт нэмэх, эмнэлэгт өргөтгөл хийх, албан бус төлбөр авч байгааг анхаарах, орон ээргүй, архи уудаг хүмүүсийн хоног төөрүүлдэгийг болиулах арга хэмжээ авахыг хүсэж байна.

ХСҮТ-ийн 138 амбулаторын үйлчлүүлэгч, 140 хэвтэн эмчлүүлэгч, нийт 277 хэрэглэгч судалгаанд хамрагдан санал, хүсэлтээ илэрхийлэв. ХСҮТ -ийн хувьд тусламж, үйлчилгээний хүлээгдэл их, эм тариа хувиасаа авчруулдагт хамгийн их бухимдалтай, хүлээх хугацаандаа нас барах асуудал гарахыг үгүйсгэхгүй байна. Эмч, ажилчид маш хүнд нөхцөлд ачаалал ихтэй ажиллаж байгааг анхаарч цалинг нэмэх, машины зогсоолыг нэмэгдүүлэх, өргөтгөлийг ашиглалтад оруулах, үйлчилгээ, цэвэрлэгээний ажилтны харилцааг сайжруулах, хөдөөнөөс ирж буй хүнд шуурхай үйлчлэх, мэдээлэл, сурталчилгааг нэмэгдүүлэхийг хүссэн байна.

АӨСҮТ-ийн 163 амбулаторын үйлчлүүлэгч, 119 хэвтэн эмчлүүлэгч, нийт 283 хэрэглэгч судалгаанд хамрагдан санал, хүсэлтээ илэрхийлэв. АӨСҮТ-ийн хувьд сувилагч нар харилцаа муутай, өөрсдийн ажилчид дугаар дайран, таньдаг хүнээ үзүүлдэг, дугаар авсан цагтаа үзүүлж чаддаггүй, хоолны амт чанар муу, хуванцар шанагаар хоол аягалдагт дургүйцэл илэрхийлсэн байна. Тусламж, үйлчилгээг шуурхай үзүүлэх, эмчийн мэдлэгийг сайжруулах, халаалтыг нэмэгдүүлэх, өрөөнд суух сандлын тоог нэмэх, орны хүлээгдэл, ор гарсан талаар мэдээлэл өгч байх, өрөөний цэвэрлэгээг сайжруулах, өрөөндөө залгууртай болох, 7 хоногийн 1 өдөр эмч арьсны өвчний талаар мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийдэг байх, машины зогсоолын асуудлыг шийдвэрлэхийг хүссэн байна.

ХТС-ийн 44 сахиур судалгаанд хамрагдан санал, хүсэлтээ илэрхийлэв. ХТС-ийн хувьд хэрэглэгчдийн сэтгэл ханамж өндөр, олон хүн талархал илэрхийлснийг онцолж байна. Хүүхдийн оройн хоол,хоолны нэр төрлийг нэмэгдүүлэх, хүүхдийн хоолны зөвлөгөө авахыг хүссэн байна. ГҮТ-ийн 54 амбулаторын үйлчлүүлэгч хамрагдсан санал, хүсэлтээ илэрхийлэв. ГҮТ-ийн хувьд цөөнгүй ахмадууд дүүрэг харгалзахгүй үйлчилдэг ганц байгууллагадаа талархсанаа илэрхийлсэн байна. Байгууллагын барилга байшин, өрөө тасалгаа тохижолт муутай, эмчилгээний өрөөнүүдийн хүрэлцээ муу, нэг өрөөнд олон эмчилгээ хийдэг, шинэ байр нь ашиглалтад орохгүй байгаад ахмадууд бухимдаж, шинэ эмнэлгийг яаралтай ашиглалтад оруулан, хэвтүүлэн эмчилж өгөөч гэж хүссэн байна.

БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Тусламж, үйлчилгээний тэгш байдал, ашиг сонирхолыг тусламж, үйлчилгээний тэгш байдал, ашиг сонирхол, энэ талаарх хэрэглэгчдийн санал, хүсэлтийн нэгтгэн 3 дэд бүлгийн хүрээнд 6 хэмжигдэхүүнээр амбулатор, хэвтэн эмчлүүлэгчээр харьцуулан судлав.

ХҮСНЭГТ 11. ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЭГШ БАЙДАЛ, АШИГ СОНИРХОЛ

Эмнэлгийн нэр	5.1. Тусламж, үйлчилгээ авах, хүлээгдлийг багасгах, үйлчилгээг шуурхай болгохын тулд шан харамж, албан бус төлбөр өгөх шаардлага гардаг			5.2. Гаднаас эм, тариа авахуулдаг			5.3. Эмнэлэгт таних хүнгүй бол тусламж, үйлчилгээ авахад хүндрэлтэй			5.4. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь хувийн эмнэлэг, эм, эмийн сан, сүлжээ санал болгодог, хувиасаа эм зардаг			5.5. Эрүүл мэндийн давталгүй тохиолдолд тусламж, үйлчилгээг чирэгдэлгүй авах боломжтой			5.6. Үйлчлүүлэгч эмчээ сонгож үзүүлэх боломжтой			
	Тийм	Үгүй	Мэдэхгүй	Тийм	Үгүй	Мэдэхгүй	Тийм	Үгүй	Мэдэхгүй	Тийм	Үгүй	Мэдэхгүй	Тийм	Үгүй	Мэдэхгүй	Тийм	Үгүй	Мэдэхгүй	
УТЭ	ХЭ	20.7	44.1	35.1	46.4	30.6	23.0	33.3	33.3	33.3	15.8	48.6	35.6	29.7	27.0	43.2	39.2	21.6	39.2
	АҮ	11.4	62.0	26.6				32.0	51.2	16.8	12.5	58.2	29.3	12.1	61.3	26.6	47.1	28.3	24.6
УИПЭ	ХЭ	13.7	64.1	22.1	23.7	61.8	14.5	16.0	62.6	21.4	10.7	76.3	13.0	29.0	28.2	42.7	35.1	23.7	41.2
	АҮ	15.1	61.8	23.1				18.4	57.3	24.3	15.6	56.5	28.0	31.9	28.1	40.0	41.1	24.9	34.1
УИПЭ	ХЭ	23.2	36.2	40.6	49.8	26.1	24.2	39.6	32.4	28.0	14.5	47.8	37.7	27.5	36.2	36.2	30.4	23.2	46.4
	АҮ	28.9	40.9	30.2				48.8	29.3	21.9	17.8	40.1	42.1	21.5	43.0	35.5	28.9	34.3	36.8
ЭЖМҮТ	ХЭ	12.0	55.4	32.5	9.3	73.0	17.7	21.4	50.8	27.8	5.7	71.3	23.1	34.4	26.7	38.9	28.6	29.4	41.9
	АҮ	28.4	31.9	39.7				43.5	31.0	25.4	22.0	36.2	41.8	20.7	42.2	37.1	24.6	37.1	38.4
ХӨСҮТ	ХЭ	14.3	37.5	48.2	28.4	36.0	35.6	18.8	35.3	46.0	9.3	48.9	41.8	25.6	27.4	47.1	16.7	25.3	57.9
	АҮ	11.9	59.7	28.4				18.2	56.1	25.8	9.0	58.2	32.8	53.8	23.1	23.1	55.2	14.9	29.9
СЭМҮТ	ХЭ	26.9	59.6	13.5	21.2	63.5	15.4	26.9	59.6	13.5	21.2	67.3	11.5	57.7	11.5	30.8	53.8	25.0	21.2
	АҮ	27.8	33.3	38.9				27.8	61.1	11.1	27.8	55.6	16.7	44.4	22.2	33.3	55.6	16.7	27.8
ГССҮТ	ХЭ	31.2	34.9	33.9	59.6	26.8	13.7	31.2	41.9	26.9	15.3	53.2	31.6	39.8	24.9	35.4	42.8	18.3	38.9
	АҮ	38.6	30.7	30.7				56.3	19.5	24.1	26.4	34.5	39.1	35.6	35.6	28.7	28.7	39.1	32.2
ХСҮТ	ХЭ	8.8	80.3	10.9	27.5	62.3	10.1	9.4	69.1	21.6	4.3	74.8	20.9	34.1	25.4	40.6	55.9	10.3	33.8
	АҮ	18.9	57.6	23.5				34.1	50.4	15.5	19.8	51.9	28.2	33.6	38.9	27.5	49.6	24.1	26.3
АӨСҮТ	ХЭ	17.6	48.7	33.6	13.4	67.2	19.3	26.9	44.5	28.6	11.8	68.9	19.3	33.9	29.7	36.4	42.0	23.5	34.5
	АҮ	17.8	39.9	42.3				22.1	51.5	26.4	12.3	49.1	38.7	34.4	25.2	40.5	40.5	19.6	39.9
ХТС	ХЭ	9.1	45.5	45.5	14.0	69.8	16.3	20.5	61.4	18.2	13.6	63.6	22.7	27.9	23.3	48.8	34.1	18.2	47.7
	АҮ	0.0	92.6	7.4				7.4	88.9	3.7	3.8	92.3	3.6	55.6	33.3	11.1	75.5	18.9	5.7
Дундаж	ХЭ	18.0	48.5	33.4	32.1	47.4	20.5	25.3	45.4	29.3	11.4	59.8	28.7	32.3	27.5	40.2	35.3	22.6	42.2
	АҮ	20.2	49.8	30.0				33.8	45.0	21.2	16.4	49.8	33.8	27.1	40.4	32.5	39.7	28.4	31.8

Тусламж, үйлчилгээ авах, хүлээгдлийг багасгах, үйлчилгээг шуурхай болгохын тулд шан харамж, албан бус төлбөр өгөх шаардлага дунджаар 18.0-20.0%-тай байна. Энэ үзэгдэл ГҮТ-д гараагүй бол ХТС-хамгийн бага хувиар байна.

ЭМСЯ-НЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

Харин ГССҮТ хамгийн их тохиолддог магадлал байна. Дийлэнхдээ амбулаториор үйлчлүүлэхдээ шан харамж, албан төлбөр илүү өгдөг байдал анзаарагдаж байгаа нь тусламж, үйлчилгээний хүлээгдэл, эмнэлэгт хэвтэх орны хүлээгдэлтэй шууд хамааралтай байхаар харагдаж байна.

Эмнэлэгт хэвтэхэд гаднаас эм тариа авхуулдаг байдал нийтлэг үзэгдэл болсон байна. ЭХЭМҮТ-ийн хэвтэн эмчлүүлэгчид хамгийн бага хувиар авхуулдаг гэсэн бол, ГССҮТ УИИТЭ, УИТЭ-ийн эмчлүүлэгчдийн бараг 50.0 орчим хувь нь энэ тухай хэлсэн байна.

Судалгаанд оролцогчдын 25.3-38.8% нь эмнэлэгт таних хүнгүй бол тусламж, үйлчилгээ авахад хүндрэлтэй гэсэн ба хамгийн их хүндрэлтэй байгууллагад ГССҮТ, УИИТЭ, ЭХЭМҮТ орж байна.

Эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь хувийн эмнэлэг, эм, эмийн сан, сүлжээ санал болгодог, хувиасаа эм зардаг гэж 11.4% - 16.4% нь үзэж байна.

Эрүүл мэндийн даатгалгүй тохиолдолд тусламж, үйлчилгээг чирэгдэлгүй авах боломжийг 21.1-32.3% нь зөвшөөрсөн байна. Эмчээ сонгон үйлчлүүлэх боломжтой гэж хэвтэн эмчлүүлэгчдийн 35.3-39.7% нь үзсэн байна.

Нээлттэй асуулгаас харахад хэрэглэгчдийн цөөнгүй хэсэг нь гаднаас эм тариа авчруулдаг, эмч, мэргэжилтэн өвчтөнд ялгавартай ханддаг, танил талдаа илүү үйлчилдэг, хүлээгдэл их байх тутам ашиг сонирхолын зөрчил гарч, хувийн эмнэлэг, лабортор санал болгож байна .

НЭГДСЭН ДҮГНЭЛТ


Судалгаанд ЭМСЯ-ны харьяа 10 эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлсэн 1596 хэвтэн эмчлүүлэгч, 1490 амбулаторын үйлчлүүлэгч, нийт 3087 хэрэглэгч хамрагдлаа.

Судалгаанд хамрагдсан 3087 хэрэглэгчийн 38.4% эрэгтэйчүүд, 61.6 хувь нь эмэгтэйчүүд дийлэнх нь 20-49 насныхан буюу 62.3% байна. Нийт оролцогчдын 55.2 хувь нь тухайн эмнэлгээр анх удаа үйлчлүүлсэн, 44.8% нь 2 ба түүнээс дээш удаа үйлчлүүлсэн хүмүүс байна.

Судалгаанд хамрагдсан 1596 хэвтэн эмчлүүлэгчийн сэтгэл ханамжийн ерөнхий дундаж түвшин 87.6%, 1.25 баллтай, 1490 амбулаторын үйлчлүүлэгчдийн 80.9% нь 1.36 баллтай, нийт хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшин “сайн” үнэлгээтэй байна.

Хэвтэн эмчлүүлэгчдийн үнэлгээгээр ХСҮТ сэтгэл ханамжийн түвшин хамгийн өндөр байгууллага болж байна. ГССҮТ нь амбулаторын үйлчлүүлэгчдийн үнэлгээгээр сэтгэл ханамжийн түвшин хамгийн бага байгууллага болж байна.

ЗУРАГ 77. ХЭРЭГЛЭГЧДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ЕРӨНХИЙ ТҮВШИН



Нийтлгээр хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин амбулаторын үйлчлүүлэгчдээс тогтмол өндөр байна.

ЭМСЯ-НЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

Сэтгэл ханамжийн ерөнхий түвшинг бүлгээр, амбулатор:стационараар харьцуулан авч үзвэл, байгууллагын соёлд 79.5 :85.5%, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёлд 84.6:91.4%, тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдалд 81.4:88.4%, удирдлага зохион байгуулалтад 76.8:83.8%-тай байна.

Үзүүлэлтээс харахад байгууллагын соёлд $17.5 \pm 3 \%$, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёлд $12.0 \pm 3.4\%$, тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдалд $15.1 \pm 3.5 \%$, удирдлага зохион байгуулалтад $19.7 \pm 3.5\%$ нь сэтгэл ханамжийн түвшин хангалтгүй байна.

Энэ нь нээлттэй асуулгаар судлагдсан тусламж, үйлчилгээний хүлээгдэл ихтэй, цахим бүртгэлийн зохион байгуулалт, үйлчилгээний соёл хангалтгүй, эмч, эмнэлгийн мэргэжилтний чин сэтгэлийн харилцаа, ёс зүй, инээмсэглэн угаж, мэндчлэх үйлчилгээ, зөвлөгөө өгөх үйлчилгээ дутагдалтай, үйлчлүүлэгчиддээ ялгавартай ханддаг, гаднаас эм тариа авчруулдаг, зарим тохиолдолд албан бус төлбөр өгөх шаардлага гардаг зэрэгтэй шууд хамааралтай байна.

ХҮСНЭГТ 12. ХЭРЭГЛЭГЧДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ЕРӨНХИЙ ТҮВШИН

Эмнэлгийн нэр		Нэг. Байгууллагын соёл		Хоёр. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээний соёл		Гурав. Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал		Дөрөв. Удирдлага, зохион байгуулалт		Дундаж	
		Балл	%	Балл	%	Балл	%	Балл	%	Балл	%
УИТЭ	ХЭ	1.24	88.0	1.09	95.3	1.15	92.4	1.21	89.4	1.17	91.5
	АҮ	1.41	79.6	1.37	81.7	1.36	81.9	1.45	77.5	1.39	80.6
УИИТЭ	ХЭ	1.16	92.2	1.04	97.8	1.10	95.0	1.17	91.3	1.11	94.4
	АҮ	1.23	88.5	1.15	92.6	1.20	89.9	1.32	83.8	1.22	89.2
УИИИТЭ	ХЭ	1.36	82.1	1.21	89.5	1.28	86.1	1.43	78.7	1.30	84.8
	АҮ	1.46	76.8	1.34	82.8	1.43	78.3	1.56	71.9	1.44	77.9
ЭХЭМҮТ	ХЭ	1.29	85.5	1.18	91.0	1.24	88.2	1.37	81.7	1.26	87.2
	АҮ	1.57	71.6	1.47	76.7	1.53	73.6	1.62	68.9	1.54	73.0
ХӨСҮТ	ХЭ	1.42	78.9	1.31	84.4	1.36	82.2	1.47	76.7	1.38	81.1
	АҮ	1.46	77.2	1.36	82.1	1.31	84.4	1.29	85.6	1.36	81.9
СЭМҮТ	ХЭ	1.15	92.3	1.16	92.0	1.15	92.4	1.18	91.1	1.16	92.1
	АҮ	1.15	92.3	1.15	92.6	1.14	92.9	1.24	88.2	1.16	92.0
ГССҮТ	ХЭ	1.46	76.9	1.28	85.9	1.36	82.0	1.47	76.3	1.39	80.7
	АҮ	1.70	65.0	1.36	82.2	1.58	70.8	1.84	58.0	1.61	69.7
ХСҮТ	ХЭ	1.09	95.7	1.03	98.7	1.06	96.9	1.08	96.0	1.06	96.8
	АҮ	1.31	84.7	1.24	87.9	1.30	85.0	1.40	79.9	1.30	84.8
АӨСҮТ	ХЭ	1.28	85.8	1.14	92.8	1.27	86.4	1.30	85.2	1.25	87.4
	АҮ	1.32	84.0	1.23	88.5	1.35	82.5	1.36	82.2	1.32	84.1
ХТС	ХЭ	1.19	90.3	1.11	94.4	1.15	92.5	1.29	85.6	1.17	91.5
ГҮТ	АҮ	1.17	91.7	1.01	99.4	1.10	95.2	1.08	95.9	1.10	95.1
Дундаж	ХЭ	1.29	85.3	1.17	91.4	1.23	88.4	1.32	83.8	1.25	87.6
	АҮ	1.41	79.5	1.31	84.6	1.37	81.4	1.46	76.8	1.38	80.9

Байгууллагаар авч үзвэл хэвтэн эмчлүүлэгчид өндөр хувиар үнэлсэн (90.0-ээс дээш хувьтай) байгууллагад ХСҮТ, УИИТЭ, УИТЭ, СЭМҮТ, ХТС орж байна.

Хэвтэн эмчлүүлэгчдээс 80.0-аас доош үнэлгээ авсан байгууллага байхгүй байна. Хамгийн бага нь ГССҮТ нь 80.7%-тай, 1.39 баллтай байна.

Амбулаторын үйлчлүүлэгчид өндөр хувиар үнэлсэн (90.0-ээс дээш хувьтай) байгууллагад СЭМҮТ, ХТС, ГҮТ орж байна. Хамгийн бага нь ГССҮТ нь 69.7%-тай, 1.61 баллтай байна.

Судалгааны үр дүнд судалгааны хугацаа нөлөөлж байна. Тухайлбал, Хугацаа нь эмнэлгүүдийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлэх үетэй давхцдаг тул хэрэглэгчид, ялангуяа хэвтэн эмчлүүлэгчид нь өндөр үнэлгээ өгөх хандлага анзаарагдаж байна.

ЗӨВЛӨМЖ

ЭМСЯ-ны харьяа байгууллагууд нь судалгааны үр дүнгийн тайлан, нээлттэй асуулгаас гарсан хэрэглэгчдийн санал, хүсэлтийг үндэслэн, төлөвлөлтөд тусган хэрэгжилтийг хангаж ажиллах

Судалгааны үр дүнд суурилан авсан арга хэмжээг тухай бүр нээлттэй ил тод тайлагнах, мэдээлэх, тогтвортой байдлыг хангах

Хэрэглэгчдийн сэтгэл ханамжгүй үнэлгээ өгсөн чиглэл бүрээр, байгууллагууд тулгамдсан асуудлаа тодорхойлон, дүн шинжилгээ хийж, авсан арга хэмжээг дараа жилийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайланд тусган, хэрэгжилтийг үнэлүүлдэг тогтолцоонд шилжиж, судалгааны үр дүн, ач холбогдолыг дээшлүүлэх

Судалгааны асуумжын үнэлгээг 5 баллын системд шилжүүлэн, баллын үнэлгээний аргачлалыг оновчтой болгох, эрүүл мэндийн байгууллагуудыг судалгаа хийх мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах

Судалгааны хэмжигдэхүүнийг жил бүр харьцуулах боломжтой тогтмол хувьсах хэмжигдэхүүн, салбарын тухайн жилийн зорилго, чиглэлтэй уялдсан үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлэх өөрчлөгдөж байдаг хувьсах хэмжигдэхүүн гэж ангилан, шинэчлэх

Судалгааны үр дүнд судалгааны хугацаа нөлөөлж буйг анхааралдаа авч, урьдчилсан төлөвлөлтөөр хийх